



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР

**ГЕОЛОГИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨСВИЙН НОРМЫН ЛАВЛАХ НЬ
ӨНӨӨГИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БОЛЖ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ
ХАНГАЛТГҮЙГЭЭС ЭРСДЭЛИЙГ УДИРДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН СЭДЭВ: “УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН
ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/21-ШТА-ГА

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд
Утас:263755 Цахим хаяг: Enkhboldd@audit.gov.mn

Эрсдэлийн удирдлагын газрын захирал Д.Отгонбаяр
Утас:264004 Цахим хаяг: Otgonbayard@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор М.Наранжаргал
Утас:262451 Цахим хаяг: Naranjargalm@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Золбаяр
Утас:262451 Цахим хаяг: Zolbayarb@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор М.Баяртогтох
Утас:262451 Цахим хаяг: Bayartogtokhm@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор Б.Буянхишиг
Утас:262451 Цахим хаяг: Buyankhishigb@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор Г.Сарангоо
Утас:262451 Цахим хаяг: Sarangooq@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитор Н.Уртнасан
Утас:262451 Цахим хаяг: Urtnasann@audit.gov.mn

2024 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Аж Үйлдвэржилтийн байнгын хороо болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Үндэсний геологийн албанд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд (Ц.Туваан), Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнхтөр) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивад хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.



Д.ЗАГДЖАВ

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2024 оны 12 дугаар сарын 12-ний
өдрийн 9/9 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Албан шаардлагын товч утга	Албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Сайд Ц.Туваан	ЭБМЗ-ийн "Геологийн асуудал хэлэлцэх салбар зөвлөл"-ийн хурлаар Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх геологийн судалгааны ажлын төслийн төсөвт өртгийг зохиоход БНМАУ-ын Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яамны сайдын 1988 оны 329 дүгээр тушаалаар батлагдсан Геологи үйлдвэр шинжилгээний институтийн эдийн засгийн сектороос боловсруулсан "Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах /ТНЛ/-ыг хэлэлцүүлж дүгнэлт гаргах, уг нормыг шинэчлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	-
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Сайд Ц.Туваан	Уул уурхайн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 3.14, 3.15 дахь заалттай нийцүүлж аргачлал, хяналтын зарим зардлыг төлөвлөөгүй, зарцуулаагүй байх тул зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хяналт хэрэгжүүлэн ажиллах.	Төлөвлөлт /155,694,647.0/ Зарцуулалт /143,043,636.0/ Нийт 298,738,283.0
3	Үндэсний геологийн алба	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтөр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 3.2.18, 3.2.19, 3.2.22 дахь заалттай нийцүүлж аргачлал, хяналтын зарим зардлыг төлөвлөөгүй, зарцуулаагүй байх тул зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хяналт хэрэгжүүлэн ажиллах.	Төлөвлөлт /365,097,548.0/ Зарцуулалт /55,001,000.0/ Нийт 420,098,548.0
4	Үндэсний геологийн алба	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтөр	Монголын стратиграфийн комисс болон Монголын зургийн редакц нь дүрмийн холбогдох заалтуудыг зөрчсөн асуудлыг таслан зогсоох.	-
	Нийт			718,836,831.0

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	1
Хүснэгтийн товьёг	2
Дүрслэлийн товьёг	2
Графикийн товьёг	2
Хавсралтын товьёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	3-4
Ерөнхий мэдээлэл	5
БҮЛЭГ I. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ БОЛОН ДҮРЭМ, ЖУРМААР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЧАНАР, ҮР ДҮНГ БОДИТОЙ ҮНЭЛЖ, ЭРСДЭЛИЙГ УДИРДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.	6-22
- Нэг. Төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлыг төлөвлөхдөө холбогдох журмын заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.	7-8
- Хоёр. Геологийн судалгааны ажлын үр дүнгээр 1:50000 масштабаар Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 46.2 хувийг бүрхсэн байна.	9
- Гурав. Үйл ажиллагааны стратегийн зарим чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгаагүйгээс үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байх, боловсон хүчин, хүний нөөцөөр хангагдахгүй байх эрсдэл бий болжээ.	9-12
- Дөрөв. 2018-2024 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад зарим гүйцэтгэгчийн үйл ажиллагааны чиглэл нь хүчингүй төлөвтэй байжээ.	13-14
- Тав. Орон тооны бус комисс, зөвлөл нь Үндэсний геологийн албатай нууцлалын гэрээ байгуулаагүйгээс мэдээлэл алдах эрсдэлтэй, геологийн судалгааны ажлын чанар, үр дүнд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.	15
- Зургаа. Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналтын үр нөлөө хангалтгүйгээс Геологийн бодлогын газар болон Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны эрсдэлийг удирдаж чадахгүй байна.	16
- Долоо. Үндэсний геологийн алба нь Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакцтай нууцлалын гэрээ байгуулаагүйгээс геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээлэл алдагдах эрсдэлийг үүсгэж байна.	17
- Найм. Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	18-22
БҮЛЭГ II. ГЕОЛОГИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨСВИЙН НОРМЫН ЛАВЛАХ НЬ ӨНӨӨГИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БАЙНА.	23-33
- Нэг. 1988 оны геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байгаа нь 1 км.кв-д өртөг болон зардлын үнийн хэт ялгааг үүсгэж байна.	23-27
- Хоёр. Геологийн судалгааны ажлын санхүүжилтийг тухайн жилийн гүйцэтгэлд үндэслэн олгосон ч аргачлал, хяналтын зардлаар суутгаж авсан дүнгээс 162.3 сая төгрөгийг журмын дагуу зарцуулаагүй байна.	28-29
- Гурав. Үндэсний геологийн алба шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ-дотоод аудитын газраас эрсдэлийг хянаж чадаагүй байна.	30
- Дөрөв. Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэх шаардлага бий болжээ.	31-33
Мэргэжлийн геологичдоос авсан санал, асуулгын дүн	34
Геологийн салбарын чиг үүргийг бусад улстай харьцуулсан дүн	35-36
Дүгнэлт	37
Зөвлөмж	38
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	39-43
Үндэсний аудитын газрын тайлбар	44
Хавсралт	45-47

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуй, нэгж байгууллага
АНУ	Америкийн нэгдсэн улс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНКаЗУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГБГ	Геологийн бодлогын газар
ГБТА	Геологийн баримтын төв архив
ГЗЕЭА	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил
ГМТ	Гео-мэдээллийн төв
ГСА	Геологийн судалгааны ажил
ГСХ	Геологийн судалгааны хэлтэс
ГҮШ	Геологи үйлдвэр шинжилгээ
ГСАХСЗ	Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл
ЗГАЭЗБТХ	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
ЗГҮА	Засгийн газрын үйл ажиллагаа
МСК	Монголын стратиграфийн комисс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИС	Монгол Улсын Их сургууль
НБД	Нарийн бичгийн дарга
НМИТБТХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
РЗ	Редакцын зөвлөл
СХГ	Салбарын хяналтын газар
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗУХ	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТНЛ	Төсвийн нормын лавлах
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТХ	Төсвийн тухай хууль
ТҮХ	Тендерийн үнэлгээний хороо
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХ	Улсын төсвийн хөрөнгө
УТХГГСАСГҮДТЖ	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам
УУС	Уул уурхайн сайд
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮГА	Үндэсний геологийн алба
ҮХС	Үйлдвэр худалдааны сайд
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШХ	Хээрийн шуурхай хяналт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их сургууль
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ЭБСТЭЗХ	Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	АМГТГ болон ҮГА-аас 2018-2024 онд УУХҮЯ-нд хүргүүлсэн УТХ-өөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын төслийн саналын хураангуй мэдээлэл	7
Хүснэгт 2	Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн бүтцийн өөрчлөлт /2016-2024 оны эхний хагас жилийн байдлаар/	10
Хүснэгт 3	ҮГА-ны 2020-2023 оны бүтэц, орон тооны өөрчлөлт, шинэчлэлт	12
Хүснэгт 4	Үнэлгээний хорооны гишүүдийн тоо болон байгууллагын харьяалал	14
Хүснэгт 5	2018-2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан болон хасагдсан ГСА-ын мэдээлэл	14
Хүснэгт 6	Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл	15
Хүснэгт 7	2018-2024 онд шинээр хэрэгжүүлэх ажлын нэгтгэл	15
Хүснэгт 8	ХШХ, УРЗ, МСК болон ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн үйл ажиллагааны чиглэл	16
Хүснэгт 9	Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуултай холбоотой асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн гишүүдийн 2018-2024 оны томилгооны судалгаа	19
Хүснэгт 10	ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн ажлын нэгтгэл	21
Хүснэгт 11	УТХ-өөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн ГСА-ын үр дүнгийн тайлан гараагүй талбайд Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон судалгаа	22
Хүснэгт 12	2014-2022 онд хооронд эхлэх хэрэгжих зураглалын ажлын 1км2 талбайн өртөг, зардал	24
Хүснэгт 13	ГСА-ын яоцад 1 ширхэг шлэх сорьц авч угаах өртөг болон 1км.кв талбайд ноогдох сорьцын тоо	25
Хүснэгт 14	ГСА-уудын суурин боловсруулалтын хугацаа, нэгжийн өртгийн харьцуулалт	26
Хүснэгт 15	ГСА-ын 1 км.кв талбайд ноогдох тээврийн зардал болон түлш шатахууны үнэ	26
Хүснэгт 16	ГСА-ын тээврийн зардлын ялгаатай байдал	27
Хүснэгт 17	ГСА-аар хээрийн судалгааны ажлын томилолтын зардал болон 1км2 талбайд ноогдох томилолтын хоног	27
Хүснэгт 18	УТХ-өөр 2018-2024 онд хэрэгжсэн ажлуудын төсөвт өртөг	28
Хүснэгт 19	УТХ-өөр 2018-2024 оны аргачлал, хяналтын зардлыг төвлөрүүлэх дүн, бодит орлого болон түүний зарцуулалт	29
Хүснэгт 20	Монгеокат системд үр дүнг оруулаагүй ажил	32
Хүснэгт 21	Санал асуулга, хариултын нэгтгэл	34
Хүснэгт 22	Монгол Улсын болон зарим улс орны Геологийн албадын үйл ажиллагааны чиглэлийн харьцуулалт	35

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Геологийн салбарын удирдлагын тогтолцоо	6
Дүрслэл 2	УУХҮЯ-ны ГБГ-ын үйл ажиллагааны стратегийн өөрчлөлтүүд	10

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	“УГЗ-200 нэгтгэл К, L, M” ажлын явцын мэдээлэл	9
График 2	2017-2024 оны хооронд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн зардал өссөн ажлуудын 1 км.кв талбайд зарцуулах зардал	24
График 3	ГСА-аар суваг болон шурф ухах, буцааж булах 1м.куб-ийн өртөг, зардал	26
График 4	Нийт геологийн судалгааны ажлын төрлүүдийн эзлэх хувь	28

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	АМГТГ болон ҮГА-аас 2018-2024 онд УУХҮЯ-нд хүргүүлсэн УТХ-өөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын төслийн санал	45
Хавсралт 2	АМГТГ, ҮГА-аас УУХҮЯ-нд хүргүүлсэн санал, УУХҮЯ-аас СЯ-нд хүргүүлсэн санал болон УУХҮС-ын тушаалаар баталсан ГСА-ын өөрчлөлтийн хураангуй мэдээлэл	46
Хавсралт 3	Улсын төсвийн хөрөнгөөр 2018-2023 оны хооронд хэрэгжүүлж дууссан судалгааны ажлыг ЭБМ-ийн ГСАХСЗ-ийн 2024 оны эхний хагас жилийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дэгт тусгасан 21 ажлын жагсаалт	47

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх сэдэв”, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	УТХ-өөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнг дүгнэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, УИХ-ын холбогдох байнгын хороо болон АҮЭБЯ, ҮГА-ны албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх геологийн судалгааны ажлыг урт, дунд хугацааны зорилттой уялдуулан төлөвлөж, оролцогч талууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү? 2. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын үе шатны хяналт үр нөлөөтэй байж, судалгааны үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Ашигт малтмалын тухай хууль, Монгол Улсын 2018-2024 оны Төсвийн тухай хуулиар “Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд” ТЭЗ-ийн төсөв зарцуулах “Хөрөнгийн зардал”, Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийх ажлын төлөвлөлт болон мөн онуудад УУХҮС-ын тушаалаар “Улсын хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө” баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих чиг үүрэгтэй яамны ГБГ, ХШҮДАГ, Үндэсний геологийн алба, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”, “Монголын Стратиграфийн комисс”, Улсын зургийн редакцын зөвлөл /орон тооны бус/, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, бусад оролцогч талуудыг хамрууллаа.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглаж гүйцэтгэв. УУХҮС-ын 2018-2024 оны тушаалаар баталсан “Улсын хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө”-нд тусгасан геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийн даалгавар, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, төслийн гэрээ, төслийн хэрэгжилт түүний үр дүнгийн тайлан, геологийн судалгааны ажилд холбогдох комисс, зөвлөлөөс хийсэн үе шатны хяналтын тайлан, хуралдааны тэмдэглэл, дүгнэлт, шийдвэр, гэрээ дүгнэсэн акт, олгогдсон санхүүжилт зэрэг холбогдох баримт материалыг үндэслэн нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, төрийн захиргааны төв байгууллага, хэрэгжүүлэгч агентлаг, орон тооны бус зөвлөл, оролцогч талуудын асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Хууль: • Ашигт малтмалын тухай хууль /2006 он/; • Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; /1997 он/ • Төрийн албаны тухай хууль /2017 он/; • Төрийн болон албаны нууцын тухай хууль /2016 он/; • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005 он, 2023 он/; • Төсвийн тухай хууль /2011 он/; • Монгол Улсын 2018 он, 2019 он, 2020 он, 2021 он, 2022 он, 2023 он, 2024 оны Төсвийн тухай хуулиуд; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/; • Шилэн дансны тухай хууль /2014/; • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/. Улсын Их Хурлын тогтоол: • УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”; • УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; • УИХ-ын 2020 оны 24 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; Засгийн газрын тогтоол:

	• Засгийн газрын 2016 оны 3, 81 дугаар тогтоолоор баталсан “Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”; • Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай”; • Засгийн газрын 2018 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар”; • Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар”; • Засгийн газрын 2020 оны 230, 38 дугаар тогтоолоор баталсан “Агентлаг байгуулах тухай”; • Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”; • Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолоор “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай”; • Засгийн газрын 2024 оны 30 дугаар тогтоолоор “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”. Сангийн сайдын тушаал: • Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай”. Уул уурхай хүнд үйлдвэрийн Сайдын тушаал: • УУХҮС-ын 2015 оны А-108 дугаар, 2022 оны А-87 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх үр дүнг тооцох” журам; • УУХҮС-ын 2022 оны А-06 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаал; • УУХҮС-ын 2018 оны А/03, А/158 дугаар, 2019 оны А/13, А/109, А/234, А/254 дүгээр, 2020 оны А/232, А/319, А/322 дугаар, 2021 оны А/159, А/294, А/295 дугаар, 2022 оны А/29 дүгээр, 2023 оны А/21, А/379 дугаар “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө” баталсан тушаал; • УУХҮС-ийн 2016 оны 23 дугаар тушаалаар баталсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”; • УУХҮС-ийн 2018 оны А/48, 2019 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх салбар зөвлөл”; • УУХҮС-ийн 2018 оны А/46 дугаар тушаалаар баталсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм батлах тухай”; • УУХҮС-ын 2018 оны А/19 дугаар тушаалаар баталсан “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”; • УУХҮС-ийн 2020 оны А/239, 2022 оны А/93, 2024 оны А/36 дугаар тушаалаар баталсан “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”; • УУХҮС-ын 2021 оны А/25, А/195 дугаар тушаалаар баталсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм, аргачлал батлах тухай”; • УУХҮЯ-ны ТНБ-ийн даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хороо байгуулах тухай”. Ашигт малтмал, газрын тосны газар: • АМГТГ-ын 2017 оны А/101 дүгээр тушаалаар “Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай”; Үндэсний геологийн албаны даргын тушаал: • УГА-ны даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай”; • УГА-ны даргын 2020 оны А/45, 2021 оны А/41, 2022 оны А-02 дугаар тушаалаар баталсан “Бүтэц, орон тооны нэршил өөрчлөн батлах тухай”; • УГА-ны даргын 2021 оны А/22, 2023 оны А/04, 2023 оны А/11 дугаар тушаалаар баталсан “Монголын стратиграфийн комиссын ажиллах дүрэм, байнгын гишүүдийн бүрэлдэхүүнийг томилох тухай”; • УГА-ны даргын 2021 оны А/32 “Улсын геологийн зургийн редакцын зөвлөл байгуулах тухай, 2024 оны А/13 дугаар тушаалаар баталсан “Улсын геологийн зургийн редакцын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай”; • УУХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А/88, 2019 оны А/89, 2020 оны А/92, 2021 оны А/41, 2022 оны А-15, 2023 оны А/08, 2024 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын төлөвлөгөө, төсөв батлах тухай”.
Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээл	Аудитад шалгагдагч байгууллагууд шаардсан материалыг удаах, зарим нотлох баримтыг хангалтгүй гаргаж өгсөн нь аудитын горим хэрэгжүүлэх явцад цаг хугацааны хувьд хүлээлт үүсгэж байсан.

Ерөнхий мэдээлэл


Монгол Улсын 2018 он, 2019 он, 2020 он, 2021 он, 2022 он, 2023 он, 2024 оны Төсвийн тухай хуулиар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн” төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв “Хөрөнгийн зардал”-д нийт 149,999.0 сая төгрөгийн төсөв баталж, хөтөлбөрийн зорилтыг “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнд талбайн хамрагдалтын хэмжээ, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн тоо, хэмжээг нэмэгдүүлнэ” гэж тодорхойлжээ.

УУХҮС-ын 2018 оны А/03, А/158 дугаар, 2019 оны А/13, А/109, А/234, А/254 дүгээр, 2020 оны А/232, А/319, А/322 дугаар, 2021 оны А/159, А/294, А/295 дугаар, 2022 оны А/29 дүгээр, 2023 оны А/21, А/379 дугаар тушаалаар “Улсын хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө” болон тодотгосон тушаалаар 2018-2024 оны хооронд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 22, шинээр хэрэгжүүлэх 67 төслийг баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө /цаашид УТХ/-өөр 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 56, ашигт малтмалын 8, геофизикийн 3, эрэл үнэлгээний 4, геологийн бусад төрлийн суурь 12, геохимийн 2, геоэкологийн 4 ажлыг 2014-2024 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлж байгаагаас 29 ажлын гэрээг дүгнэж, ЭБМ-ийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар” зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн 25 ажлаас үр дүнгийн тайланг засварлахаар буцаасан 2, УУХҮС-ын тушаал гарсан 2, тушаал гараагүй 21, үргэлжлэн хэрэгжиж байгаа 35 ажил байна.

УТХ-өөр 2018-2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 140,855.0 сая төгрөгийн 89 ажилд 113,472.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

УТХ-өөр хэрэгжүүлсэн Геологийн судалгааны ажил /цаашид ГСА/-ын 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын нийт нутаг дэвсгэрийн бүрхэлт 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 46.2 хувь буюу 722,321.1 км.кв талбайг бүрхэж, 1:200000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн “УГЗ-200 нэгтгэл К” ажлыг хүлээж авсан байна.




Аудитын явцад Геологийн салбарт геологийн зураглал, ерөнхий эрэл, ГСА, тэдгээртэй адилтгах бусад судалгааны ажлыг гүйцэтгэж байсан зөвлөх, мэргэшсэн геологич нийт 20 (2 хүн буюу 10.0 хувь нь 10-15 жил, 3 хүн буюу 15.0 хувь нь 15-20 жил, 2 хүн буюу 10.0 хувь нь 20-25 жил, 13 хүн буюу 65.0 хувь нь 25-аас дээш жил ажилласан) хүнээс 8 чиглэлээр санал, асуулгыг авч дүн шинжилгээ хийлээ.

БҮЛЭГ 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ БОЛОН ДҮРЭМ, ЖУРМААР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЧАНАР, ҮР ДҮНГ БОДИТОЙ ҮНЭЛЖ, ЭРСДЭЛИЙГ УДИРДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

1.1. АМТХ, ЗГАЭЗБТХ-ийн дагуу Засгийн газраас УУХҮЯ-ны болон ҮГА-ны “...геологи, хайгуулын салбарын бодлогыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, Монгол улсын нутаг дэвсгэрийн болон хөгжлийн бүсүүдэд геологи, эрдэс баялгийн суурь болон сэдэвчилсэн судалгаа хийх замаар геологийн судалгаа, ашигт малтмалын асуудлаар хэрэглэгчдийг нэгдсэн, төрөлжсөн мэдээллээр хангах” үйл ажиллагааны стратегийн зарим чиг үүргийг баталжээ.

Дүрслэл 1. Геологийн салбарын удирдлагын тогтолцоо



Төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлыг төлөвлөхдөө холбогдох журмын заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ыг УУС-ын 2015 оны 108 дугаар¹ тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам” /цаашид УТХГГСАСГҮДТЖ/-ын 2² дахь заалтын дагуу төлөвлөж байсан бол УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар³ тушаалаар дээрх тушаалыг хүчингүйд тооцож журмыг шинэчилснээр, шинэчлэгдсэн журмын 3.1⁴ дэх заалтын дагуу төлөвлөхөөр тусгасан байна.

Дээрх журмын дагуу УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөний төслийг 2018-2020 онд АМГТГ нь чиг үүргийн дагуу боловсруулж байсан боловч Засгийн газрын 2020 оны 230 дугаар⁵ тогтоолоор ҮГА байгуулагдсанаар дээрх эрх, үүрэг шилжсэн байна. Үүнд:

• УУХҮС-ын 2020 оны А-254 дүгээр⁶ тушаалаар баталсан “Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.2.1-т “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттайгаар төлөвлөх, гүйцэтгэлийг хангуулах, нэгдсэн арга аргачлалаар удирдах” гэж тусгаснаар 2020 оноос хойш Үндэсний геологийн алба (цаашид ҮГА) нь УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөг үе шаттайгаар төлөвлөхөөр зохицуулагджээ.

1.3. АМГТГ болон ҮГА-аас журмын дагуу 2018-2024 оны хооронд 1:25000 масштаб, 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрэл, 1:200000-ны масштабтай иж бүрдэл зураг зохиох, сэдэвчилсэн судалгаа, гадаад хамтын ажиллагааны зэрэг нийт 147,492.5 сая төгрөгийн төсөвтэй, 101 ажлын саналыг УУХҮЯ-нд хүргүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт 1/. Үүнд:

Хүснэгт 1. АМГТГ болон ҮГА-аас 2018-2024 онд УУХҮЯ-нд хүргүүлсэн УТХ-өөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын төслийн саналын хураангуй мэдээлэл

/сая.төг/

№	Он	Шинээр хэрэгжүүлэх төслийн саналын		
		Тоо	Үргэлжлэх хугацаа	Төсөв
1	2018	7	2018	-
2	2019	16	2019-2023	-
3	2020	19	2020-2024	-
4	2021	15	2021-2023	-
5	2022	22	2022-2026	38,794.5
6	2023	2	2023-2026	27,348.7
7	2024	20	2024-2027	81,349.3
Нийт		101	2018-2027	147,492.5

Эх сурвалж: АМГТГ-ын даргын 2017 оны 1/8749, 2019 оны 3/107, 1/338, 2020 оны 1/449, ҮГА-ны даргын 2021 оны 1/87, 1/138, 2023 оны 1/26, ҮГА-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 1/163 дугаар албан бичиг.

1.4. АМГТГ болон ҮГА-аас 2018-2021 онуудад саналыг төсөвгүй хүргүүлсэн, холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, их, дээд сургуулиас саналыг авч нэгтгээгүй, ЭБМЗ-ийн “ГСАХСЗ”-ийн хурлаар хэлэлцүүлээгүй, ГСА-ыг ач холбогдлоор эрэмбэлээгүй, хугацаанд нь хүргүүлээгүй зэрэг нь УТХГГСАСГҮДТЖ-ын заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

¹ УУС-ын 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 108 дугаар “Журам шинэчлэх батлах тухай”,

² Хоёр. Геологийн судалгааны ажлыг төлөвлөх

³ УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар “Журам шинэчлэн батлах тухай”,

⁴ 3.1 Геологийн судалгааны ажлын төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, даалгаврыг батлуулах

⁵ Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар “Агентлаг байгуулах тухай”

⁶ УУХҮС-ын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А-254 дүгээр “Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”,

- УТХ-өөр 2019-2023 онд шинээр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан журмын 2.2⁷, УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан журмын 3.1.2⁸ дахь заалтыг хэрэгжүүлсэн эсэх нь ирүүлсэн нотлох баримтуудаар нотлогдохгүй;
- УТХ-өөр 2018-2021 онд шинээр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөний төслийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан журмын 2.3⁹ дахь заалтын дагуу 1, 2 дугаар загвар хавсралтаар бэлтгээгүй, мөн ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хурлаар хэлэлцүүлээгүй;
- УТХ-өөр 2023 онд шинээр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөний төслийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан журмын 3.1.3¹⁰ дахь заалтад заасан хугацаанд хүргүүлээгүй байна.

1.5. 2018-2024 оны хооронд АМГТГ болон ҮГА-аас нийт 147,492.5 сая төгрөгийн төсөвтэй 101 ажлын саналыг УУХҮЯ-нд хүргүүлснээс 113,018.7 сая төгрөгийн төсөвтэй 58 ажлыг хасаж, нотлох баримтгүй 270,397.8 сая төгрөгийн төсөвтэй 63 ажлыг нэмж тусган нийт 347,990.9 сая төгрөгийн төсөвтэй 106 ажлын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.6. Гэтэл УУХҮС-ын тушаалаар ГСА-ын тухайн жилийн төлөвлөгөөг батлахдаа 239,714.4 сая төгрөгийн төсөвтэй 63 ажлыг хасаж, 57,035.3 сая төгрөгийн төсөвтэй 38 ажлыг шинээр нэмж нийт 170,943.5 сая төгрөгийн төсөвтэй 81 ажлыг хэрэгжүүлэхээр баталсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2/

Дээрх 1.4-1.6-д дурдсан зөрчлүүд нь төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага геологийн судалгааны ажлын төлөвлөлтөд УТХГГСАСГҮДТ журмыг баримталдаггүй, удирдах албан тушаалтан судлагдаагүй ажлыг оруулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

1.7. Аудитын явцад салбарын зөвлөх, мэргэшсэн геологичдоос дараах асуултаар санал асуулга авсан бөгөөд “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын төлөвлөлт, даалгавар нь үндэслэлтэй байна уу? гэж 20 хүнээс 12 хүн буюу 60 хувь нь хангалтгүй, “УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын төслийн төлөвлөлтөд мэргэжлийн байгууллага, судлаачдаас санал авч, оновчтой хийж байгаа талаарх таны үнэлэмж? гэсэн асуулгад 15 хүн буюу 75 хувь нь “Хангалтгүй” гэсэн хариултыг өгч, дараах шалтгаан байгааг хэлсэн байна. Үүнд:

- Тухайн орон нутгийн геологийн тогтоц, ашигт малтмалын зүй тогтлыг анхаардаггүй. Геофизик, геохими бүрэн багц байхгүй. Салбарын яам, агентлагт “геологийн эдийн засагч” дутмаг байгаа нь даалгавар боловсруулалт хангалтгүй хийх шалтгаан болж байна. Тухайн ажилд илрэл, эрдэсэжсэн цэг, хувирал, сулралын бүсийг үе үеийн геологичид олж тогтоон, амжилттай сайн ажиллаж байгаа ч тэдгээрийг гүн рүү нь үргэлжлүүлэн мөрдөж, тархцын хэмжээг нэмэгдүүлэх гүний судалгааны геофизикийн арга аргачлалыг иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлэх талаар бодлого, төлөвлөлтийн түвшинд анхаарахгүй байна.
- Төсөв, төлөвлөгөөг цөөн мэргэжилтний хүрээнд гаргаж байна. Эрдэмтэн судлаачдын зөвлөгөөг авдаггүй, Системтэй, судалгаатай сүүлийн үеийн тоон мэдээллийг хэрэглэдэггүй.

⁷ 2.2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) нь дараа жилд УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, их, дээд сургуулиас саналыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор авч энэхүү журмын 2.3-д заасан төлөвлөгөөний төсөлд тусгана,

⁸ 3.1.2. ҮГА нь дараа онуудад УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ыг төлөвлөхдөө холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэшсэн мэргэжилтнүүдээс саналыг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор авч нэгтгэнэ.

⁹ 2.3.Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан зарчмын дагуу төлөвлөгөөний төслийг геологийн судалгаа тус бүрээр зохиож, энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (цаашид “ЭБМЗ” гэх)-өөр хэлэлцүүлэн 3 дугаар сарын 10-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх)-д хүргүүлнэ.

¹⁰ 3.1.3 ҮГА нь энэ журмын 3.1.1-д заасан зарчмыг баримтлахдаа дараа онуудад гүйцэтгэхээр энэ журмын 3.1.2-ын дагуу ирүүлсэн ГСА-ын саналыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөв, төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор яамны геологийн асуудал харуулсан нэгжид хүргүүлнэ.


Геологийн судалгааны ажлын үр дүнгээр 1:50000 масштабаар Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 46.2 хувийг бүрхсэн ч Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтот түвшнээс 0.8 хувиар бага байна.

1.8. УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг 2014-2025 оны хооронд хэрэгжүүлэхээр анх баталж УИХ-ын 2021 оны¹¹ 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

1.9. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 3.2.3¹² зорилтын хүрээнд “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулна” гэсэн арга хэмжээний суурь түвшинг 2020 онд 40.7 хувьтай гэж баталсан байна.

- УАГ-аас 2023 оны “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан” аудитаар “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын нийт нутаг дэвсгэрийн бүрхэлт” 2023 оны жилийн эцсийн байдлаар 42.6 хувьтай гэсэн дүгнэлтийг гаргасан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 46.2 хувь буюу 722,321.1 км.кв талбайг бүрхээд байгаа нь зорилтот үр дүнгээс 0.8 хувиар бага байна;
- Мөн 1:200000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 1,564,116.00 кв.км-т гүйцэтгэсэн ба тэдгээрийн зургуудыг нэгтгэж, мэдээллийг боловсронгуй болгох зорилгоор “УГЗ-200 нэгтгэл К, L, М” төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

График 1. “УГЗ-200 нэгтгэл К, L, М” ажлын явцын мэдээлэл



Эх сурвалж: УГА

Үйл ажиллагааны стратегийн зарим чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгаагүйгээс үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байх, боловсон хүчин, хүний нөөцөөр хангагдахгүй байх эрсдэл бий болжээ.

1.10. Засгийн газрын 2016 оны 3¹³, 81¹⁴, 2018 оны 370¹⁵, 2020 оны 105¹⁶ дугаар тогтоолоор УУХҮЯ-ны зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, үйл ажиллагааны стратеги, орон тооны хязгаарыг тус тус баталсан бөгөөд тогтоолуудтай холбогдуулан яамны “геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж”-ийн нэршил, үйл ажиллагааны стратегийн зорилт хүснэгт 2-т харуулсан байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

¹¹ УИХ-ын 2021 оны 11 сарын 12 өдрийн 89 дүгээр тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хүчингүй болгосон.

¹² 3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

¹³ Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай”.

¹⁴ Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр “Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”.

¹⁵ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 370 дугаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай”.

¹⁶ Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 105 дугаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай”.

Хүснэгт 2. Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн бүтцийн өөрчлөлт /2016-2024 оны эхний хагас жилийн байдлаар/


№	Засгийн газрын тогтоолын огноо, дугаар	Нэгжийн нэр	Баталсан орон тоо	Хамрах хугацаа	
				Огноо	Жил, сар
1	2016 оны 3, 81	Геологийн бодлогын газар	8	2016.09.05-2018.12.21	2 жил 4 сар
2	2018 оны 370	Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Геологийн хэлтэс)	8	2018.12.21-2020.09.18	1 жил 10 сар
3	2020 оны 105	Геологийн бодлогын газар (Геологийн судалгаа, төлөвлөлтийн хэлтэс)	8	2020.09.18	4 жил

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 3 дугаар, 81 дүгээр, 2018 оны 370 дугаар, 2020 оны 105 дугаар тогтоол, УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/14, 2018 оны Б/145, 2020 оны А/95 дугаар тушаал.

Геологийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь 2018-2024 онд 8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

1.11. Мөн Засгийн газрын 2016 оны 81, 2028 оны 370, 2020 оны 105 дугаар тогтоолоор УУХҮЯ-ны ГБГ-ын үйл ажиллагааны стратеги дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнийг харуулбал:

Дүрслэл 2. УУХҮЯ-ны ГБГ-ын үйл ажиллагааны стратегийн өөрчлөлтүүд




1.12. Дээрх Засгийн газрын тогтоолуудаар үйл ажиллагааны стратеги болон газрын зарим чиг үүргийг өөрчлөн батлагдсантай холбогдуулан яамны ГБГ-т харьяалагдах албан тушаалуудад нэгжийн чиг үүрэг бүрэн хуваарилагдсан, орхигдсон эсвэл давхардсан эсэхийг тодорхойлоогүй, чиг үүргийн хуваарилалтын уялдааг хянаагүй, давхардал хийдлийг арилгаагүй байна. Тухайлбал:

- УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/13¹⁷ дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “ГБГ-ын үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолт”-ыг баталсан боловч үүнээс 2 хоногийн дараа буюу Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар “УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан ба 81 дүгээр тогтоолтой холбогдуулж ГБГ-ын алба хаагчдын АТТ-ыг батлаагүй байна;
- УУХҮС-ын 2016 оны Б/13 дугаар тушаалаар баталсан стратегийн “...геологийн салбарын үйл ажиллагааны заавар, стандарт аргачлал боловсруулж батлуулах...”, “...геологийн судалгааг олон улсын жишигт хүргэх дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх бодлого боловсруулах...”, “...стратегийн ач холбогдол бүхий ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах...” чиг үүргийг бүрэн тусгаагүй;
- Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор баталсан стратегийн “...геологийн салбарын үйл ажиллагааны заавар, стандарт аргачлал боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах...”, “...цацраг идэвхт ашигт малтмал хайх ажлыг бодлогын удирдамжаар хангах...” чиг үүргийг бүрэн тусгаагүй;
- Засгийн газрын 2018 оны 370 дугаар тогтоолоор баталсан стратегийн “...цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх ажлыг удирдан зохион байгуулах...”, “...салбарын статистик мэдээ гаргах...” чиг үүргийг бүрэн тусгаагүй;
- Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор баталсан стратегийн “...Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрмийг батлуулах...” чиг үүргийг бүрэн тусгаагүй байна.

1.13. Засгийн газрын 2020 оны 105 дугаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” тогтоолыг 2024 оны 06¹⁸ дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцож, яамны нэршлийг өөрчилж, 30¹⁹ дугаар тогтоолоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталжээ.

1.14. Харин Засгийн газрын 2020 оны 230 дугаар²⁰ тогтоолоор УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг УГА-ыг байгуулж, мөн сайдын 2020 оны А-254 дүгээр тушаалаар “УГА-ны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг батлахдаа “Дэд дарга /ерөнхий геологи/” 1 гэж баталсан нь Засгийн газрын 2016 оны 4²¹ дүгээр тогтоолын 6.2-т заасан чиглэлийг баримтлаагүй байна.



1.15. УГА-ны даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/03 дугаар тушаалаар УГА-ны бүтэц, орон тоог анх баталсан бөгөөд нийт 4 удаа өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан ч тогтворгүй, тухайн бүтцээр багадаа 3 сар, дээд тал нь 1 жил 7 сарын хугацаанд байсан байна.

¹⁷ УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/13 дугаар тушаал "Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолт батлах тухай"

¹⁸ Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" тогтоол

¹⁹ Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаар "Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай" тогтоол

²⁰ Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар "Агентлаг байгуулах тухай" тогтоол.

²¹ Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол

Хүснэгт 3. УГА-ны 2020-2023 оны бүтэц, орон тооны өөрчлөлт, шинэчлэлт

№	УГА-ны даргын тушаалын огноо, дугаар	Албан тушаалын нэр	Баталсан орон тоо	Хамрах хугацаа	
				Огноо	Жил, сар
1	2020 оны А/03	Дарга, дэд дарга, ТЗУХ, ГСХ, ЭБСТЭЗХ, ГМТ, ГБТА	35	2020.10.14-2020.12.25	3 сар
2	2020 оны А/45		35	2020.12.25-2021.09.13	10 сар
3	2021 оны А/41		35	2021.09.13-2022.01.31	5 сар
4	2022 оны А-02		35	2022.01.31-2023.07.25	1 жил 7 сар
5	2023 оны А/25	Дарга, ТЗУХ, ГСХ, ЭБСТЭЗХ, ГМТ, ГБТА	35	2023.07.25	-

Эх сурвалж: УГА-ны даргын 2020 оны А/03, А/45, 2021 оны А/41, 2022 оны А-02, 2023 оны А/25 дугаар тушаал.

Дээр дурдсан Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор орон тооны хязгаарыг 68 байхаар баталсан боловч 2020 оны 38²² дугаар тогтоолоор 35 болгож баталсан байна.

1.16. УГА-ны даргын 2020 оны А/45²³, 2021 оны А/41²⁴, 2022 оны А-02²⁵ дугаар тушаалаар УГА-ны бүтэц, орон тооны нэршлийг өөрчилсөн нь ЗГАЭБТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 “Тухайн агентлагийн чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- ТА3 2022 оны 04/522 дугаар албан бичгээр²⁶ “...ТА3-ийн 2021 оны 53, 54 дүгээр тогтоолоор төрийн захиргааны удирдах 4, гүйцэтгэх 11 нийт 15 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон албан бичигт “...танай байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт ороогүй байх тул таны гаргасан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Бүтэц, орон тооны нэршлийг өөрчлөн батлах тухай” А-02 дугаар тушаал эрх зүйн үндэслэлгүй, ...“Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 6.3-т заасны дагуу албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн “Батлах зөвшөөрөл” олгох боломжгүй байна. ...ТА3-ийн тогтоолоор “Батлах зөвшөөрөл” олгосон албан тушаалын тодорхойлолтыг УУХҮС-ын 2020 оны “УГА-ны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” А/254 дүгээр тушаалаар батлагдсан хөтөлбөрт өөрчлөлт орох хүртэл хугацаанд тогтвортой мөрдөн ажиллахыг анхааруулж байна.” гэж хариу хүргүүлж байжээ.

1.17. УУХҮС-ын 2020 оны А-254 дүгээр тушаалаар баталсан “УГА-ны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тусгасан УГА-т харьяалагдах албан тушаалуудад нэгжүүдийн чиг үүрэг бүрэн хуваарилагдсан, орхигдсон эсвэл давхардсан эсэхийг тодорхойлоогүй, чиг үүргийн хуваарилалтын уялдааг хянаагүй, албан хаагчдын АТТ-д нэгжийн зарим чиг үүргийг бүрэн тусгаагүй, мөн сайдын 2023 оны А/88 дугаар тушаалаар оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан 2023 оны 3 дугаар сараас хойш холбогдох алба хаагчдын АТТ-д өөрчлөлт оруулаагүй, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 2.4²⁷-д тус тус заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

УУХҮС-ын 2020 оны А-254 дүгээр тушаалаар баталсан стратегийн дараах чиг үүргийг бүрэн тусгаагүй байна. Үүнд:

²² Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 38 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоол

²³ Үндэсний геологийн албаны даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/45 дугаар “Бүтэц, орон тооны нэршил өөрчлөн батлах тухай” тушаал

²⁴ Үндэсний геологийн албаны даргын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/41 дүгээр “Бүтэц, орон тооны нэршил өөрчлөн батлах тухай” тушаал

²⁵ Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-02 дугаар “Бүтэц, орон тооны нэршил өөрчлөн батлах тухай” тушаал

²⁶ УГА-ны даргын 2022 оны 1/44 дүгээр албан бичгээр “...ГСХ, ЭБСТЭЗХ, ГБТА гэсэн нийт 3 нэгжийн төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчийн 4 албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцүүлж, “Батлах зөвшөөрөл” олгож өгнө үү.” гэж ТА3-д хүсэлт хүргүүлсэн.

272.4.Ажлын байрны шинжилгээг хийхдээ дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ:

2.4.1.байгууллагын үндсэн зорилго, зорилт, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүрэгүүд нэгжийн чиг үүрэгүүдэд бүрэн хуваарилагдаж орсон эсэхийг тодорхойлж, давхардал хийдлийг арилгах;

2.4.2.нэгжийн чиг үүрэг нь тухайн нэгжид харьяалагдах албан тушаалуудад албан ёсоор бүрэн хуваарилагдсан, орхигдсон эсвэл давхардсан эсэхийг тодорхойлж, чиг үүргийн хуваарилалтын уялдааг хянан, давхардал хийдлийг арилгах;

- “...байгууллагын үйл ажиллагаанд удирдлагын тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх...”
- “...Үндэсний геологийн албаны ажилтнуудын цаг ашиглалтыг сайжруулах...”
- “...аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх...”
- “...салбарын холбогдолтой мэдээлэл, статистик тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулах...”
- “...геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх...”
- “...Нэгжийн үйл ажиллагаанд хамаарах ажлын хүрээнд гадаад болон олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төслийг удирдан хэрэгжүүлэх, судалгаа-шинжилгээ хийх, хамтарсан бүтээл хэвлүүлэх, салбарын үйлдвэрлэл-шинжлэх ухааны хөгжлийн бодлогын санал боловсруулна...”
- “...хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хүдрийн бус, зангилгаа, талбайг ялган, тэдгээрт судалгаа хийхийг санал болгох...”
- “...эрдэс баялгийн төрөл бүрээр харьцуулсан байдлаар товхимол хэвлүүлж олон нийтийн хүртээл болгоно...”
- “...Энэ хүрээнд геологи, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн бүх төрөл, шатны ажлын үр дүнгийн тайлан, үйл ажиллагааны бүх төрлийн мэдээллийг хүлээн авах...”
- “...Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг нэгтгэх...”
- “...Архивын үйл ажиллагааг олон улсын, ижил төстэй архивын сан хөмрөгийн түвшинд хүргэх нь чухал ба тогтмол байдлаар харьцуулсан судалгаа явуулж, нэгдсэн бүртгэл, холбоодод Монгол улсыг төлөөлж гишүүнчлэлээр элсэж, үйл ажиллагаагаа сайжруулж ажиллана.” чиг үүргийг АТТ-д бүрэн тусгаагүй байна

1.18. Мөн ҮГА-нд ажиллаж байгаа албан хаагчид тухайн АТТ-ын “Албан тушаалд тавигдах тусгай шаардлага” хэсгийн боловсрол, мэргэжил, мэргэшил болон туршлагын шаардлагыг хангасан эсэхийг ирүүлсэн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийхэд мэргэжлийн шаардлагыг 1, мэргэшлийн шаардлагыг 8, туршлагын шаардлагыг 2 алба хаагч хангаагүй байна. Тухайлбал:

1. Мэргэжил:

ГБТА-ын “Мэдээлэл, технологи, цахим сан хариуцсан ажилтан” АТТ-ын тусгай шаардлагад “Геологич” мэргэжилтэй байх гэж заасан боловч одоо ажиллаж байгаа албан тушаалтан нь “Эрх зүй /042101/” мэргэжилтэй;

2. Мэргэшил:

ГМТ болон ГБТА-ын 5 албан тушаалын АТТ-ын тусгай шаардлагад “Мэргэшсэн геологич байх” гэж заасан боловч одоо ажиллаж байгаа албан тушаалтнууд нь тус сургалтуудад хамрагдаагүй;

3. Туршлага:

ГБТА-ын 2 албан тушаалын АТТ-ын тусгай шаардлагад “Салбартаа мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх” гэж заасан боловч одоо ажиллаж байгаа албан тушаалтнууд нь нийт ажилласан жил нь 4-10 сар байна.

1.19. Мөн салбарын зөвлөх, мэргэшсэн геологичдоос “УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчний нөөцийн талаар таны үнэлэмж? гэсэн асуулгад 20 хүнээс 15 хүн буюу 75 хувь нь хангалтгүй гэсэн хариултыг өгч, дараах шалтгаан байгааг хэлсэн байна. Үүнд:

- ГСА-ын зураглал, эрэл хийдэг геологич ховордсон шалтгаан нь залуу инженерийн мэргэжлийн дадлага хангалтгүй, геологичдын цалин хангамж бага, МУИС, ШУТИС-д геологич мэргэжлээр маш цөөн оюутан суралцаж байгаа элсэлт байх, боловсон хүчний дутагдалтай, геологичоор ажиллах мэргэжлийн боловсон хүчин ховордсон. Шинээр төгсөж буй цөөхөн геологичид нь мэргэжлээрээ ажиллахгүйгээс хүн хүчний дутагдалтай.

ГСА-ын гүйцэтгэгчийг 2018-2024 онд сонгон шалгаруулах явцад зарим гүйцэтгэгчийн үйл ажиллагааны чиглэл нь хүчингүй төлөвтэй байхад сонгон шалгаруулсан байна

1.20. ТБОНӨХБАҮХАТХ-иар²⁸ (2006-2023 оны хооронд мөрдөж байсан) ГСА-г хийх гүйцэтгэгчийг “Зөвлөх үйлчилгээ”²⁹ гэсэн төрлөөр шалгаруулж байсан бол 2023 онд тус хуулийг шинэчлэн, найруулсантай холбогдуулан “Зөвлөх үйлчилгээ” гэсэн зохицуулалтыг хассанаар “ажил”³⁰ гэсэн төрлөөр сонгон шалгаруулахаар хуульчилсан байна.

1.21. УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын ХАА-г зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог 2018-2021 онуудад УУХҮЯ-ны ТНБД-ын тушаалаар томилж байсан бол 2022-2024 онд ҮГА³¹-ны даргын тушаалаар байгуулан ажиллажээ.

Хүснэгт 4. Үнэлгээний хорооны гишүүдийн тоо болон байгууллагын харьяалал

№	Байгууллага	Тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн тоо						
		2018	2019	2020	2021	2022	2023	2024
1	УУХҮЯ	4	3	3	3	1	1	1
2	АМГТГ	1	2	2	-	-	-	-
3	ҮГА	-	-	-	2	4	2	2
4	ТББ, ХХК-ийн захирал	2	2	2	2	2	2	2
Нийт дүн		7	7	7	7	7	5	5

Эх сурвалж: 2018-2024 оны Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай тушаалууд.

2018-2024 онд үнэлгээний хорооны 2 гишүүнээр ТББ-ын төлөөлөл болон ХХК-ын захирлыг томилсон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4.³², шинэчилсэн найруулгын 50 дугаар зүйлийн 50.4³³ дэх заалтыг хангасан хэдий ч, 2018, 2020 онд байгуулагдсан үнэлгээний хорооны 2 гишүүн нь гүйцэтгэгч сонгон шалгаруулах явцад “ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох гэрчилгээ”-тэй болсон нь тус хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1³⁴ дэх заалттай нийцээгүй байна.

1.22. УУХҮС-ын тушаалаар 2018-2024 онд нийт 170,943.5 сая төгрөгийн төсөвтэй 81 ГСА-ыг хэрэгжүүлэхээр анх баталсан ч мөн онуудын тодотголоор 14,600.0 сая төгрөгийн хасаж баталсантай холбогдуулж 7 ГСА-ыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

Хүснэгт 5. 2018-2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан болон хасагдсан ГСА-ын мэдээлэл

/сая.төг/

№	Он	УУХҮС-ын баталсан тушаалын		ГСА-ын		Хасагдсан ГСА-ын	
		Огноо	Дугаар	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	2018	2018.01.05	A/03	7	-	-	-
2	2019	2019.01.21	A/13	17	30,658.8	-	-
3	2020	2019.12.24	A/254	21	37,566.1	3	4,373.8
4	2021	2020.12.18	A-322	15	29,178.3	-	-
5	2022	2021.12.14	A/295	18	39,073.8	4	10,226.2
6	2023	2023.02.02	A/21	2	4,198.0	-	-
7	2024	2023.12.19	A/379	1	30,268.3	-	-
Нийт				81	170,943.5	7	14,600.0

Эх сурвалж: УУХҮС-ын 2018 оны A/03, 2019 оны A/13, A/254, 2020 оны A-322, 2021 оны A/295, 2023 оны A/21, 2023 оны A/379 дүгээр тушаал.

²⁸ ТБОНӨХБАҮХАТ хуулийг 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр баталж (2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж) 2023 оны 06 сарын 16 өдөр хүчингүй болж, мөн өдрөөс эхлэн шинэчилсэн найруулгаар шинэ хууль батлагдсан (2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө) байна.

²⁹ 5.1.15-т “зөвлөх үйлчилгээ” гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн тусалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг;

³⁰ 4.1.1. “ажил” гэж барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх барааг;

³¹ УУХҮС-ын 2022 оны A/06 дугаар тушаалаар ГСА-ын төсвийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг шилжүүлсэн

³² 47.4. “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна”

³³ 50.4 Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна

³⁴ 47.3.1. худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх;

1. УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар 2020 оны “Геологийн судалгааны ажлын төсөв төлөвлөгөө батлах тухай”

- 1,066.75 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 190.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2020-2023 онд хэрэгжих “Номингийн говь-50” ГСА;
- 2,000.00 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 270.66 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2020-2022 онд хэрэгжих “Тек-500” ГСА;
- 1,307.02 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 190.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2020-2023 онд хэрэгжих “Цээл-50” ГСА.

2. УУХҮС-ын 2021 оны А/295 дугаар тушаалаар 2022 оны “Геологийн судалгааны ажлын төсөв төлөвлөгөө батлах тухай”

- 2,187.63 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 500.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2022-2025 онд хэрэгжих “Цээл-50” ГСА;
- 1,538.61 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 300.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2022-2025 онд хэрэгжих “Майхантын овоо-50” ГСА;
- 1,000.00 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 300.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2022-2024 онд хэрэгжих “СШ геоэкологи-2022” ГСА;
- 5,500.00 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 800.00 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2022-2024 онд хэрэгжих “Эрэл үнэлгээ-5-2022” ГСА.

1.23. Харин гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад 156,343.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 ГСА-аас 3 ажилд дараах 2 хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл нь хүчингүй төлөвтэй байхад сонгон шалгаруулж, гэрээ байгуулжээ. Үүнд:

Хүснэгт 6. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл

/сая.төг/

№	Хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөв	Бүртгэсэн огноо	Өөрчилсөн огноо	ГСА-ын		
						Хэрэгжих хугацаа	Нэр	Төсөв
1	Геомин ХХК	Ашигт малтмалын ашиглалт	Үгүй	2014.04.18	2018.0122	2020-2023	“Их хараат уул-50”	1,049.3
		Ашигт малтмалын хайгуул				2020-2024	“Индэртийн нуруу-50”	2,507.6
2	Геосан ХХК	Ашигт малтмалын хайгуул хийх	Үгүй	2007.05.21	2019.07.23	2020-2023	“Ховд-2020	3,000.0

Эх сурвалж: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа, 2018-2022 оны ГСА гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ

1.24. УУХҮС-ын тушаалаар 2018-2024 онд шинээр хэрэгжүүлэх 67 ажилд нийт 141,844.7 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 7. 2018-2024 онд шинээр хэрэгжүүлэх ажлын нэгтгэл

/сая.төг/

№	Хэрэгжих он	Төслийн тоо	Гэрээний нийт дүн
1	2018-2022	7	5,108.0
2	2019-2023	16	26,964.9
3	2020-2024	16	25,633.8
4	2021-2024	11	21,238.9
5	2022-2025	14	28,582.9
6	2023-2024	2	4,047.8
7	2024	1	30,268.4
Нийт		67	141,844.7

Эх сурвалж: ГСА-ын гэрээ

Орон тооны бус комисс, зөвлөл нь Үндэсний геологийн албатай нууцлалын гэрээ байгуулаагүйгээс мэдээлэл алдах эрсдэлтэй, геологийн судалгааны ажлын чанар, үр дүнд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

АМТ хуулийн дагуу УУХҮС-ийн тушаалаар ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийг, УТХГГСАСГҮДТ журмын дагуу ҮГА-ны даргын тушаалаар ГСА-ын үр дүн, чанарт хяналт хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, комисс, хяналт хэрэгжүүлэх нэгжийг дараах чиг үүрэгтэй байгуулан, үйл ажиллагаа нь явагдаж байна.

Хүснэгт 8. ХШХ, УРЗ, МСК болон ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн үйл ажиллагааны чиглэл

Хээрийн шуурхай хяналт	Улсын зургийн редакцын зөвлөл	Монголын Стратиграфийн комисс	Эрдэс баялгийн мэргэжлийн салбар зөвлөл /Геологийн судалгааны асуудал хэлэлцэх/
- Ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах, - Төсөл зохих арга, аргачлалын дагуу хэрэгжиж байгаа эсэх, - Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгаж, - Аргачлалын зөвлөгөө өгөх.	- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохиогдсон геологийн төрөл бүрийн зураг, тайлбар бичигт хяналт тавих, - Төсөл хэрэгжүүлэгчид зургийн нэгтгэл, геологийн хил заагийн маргааныг шийдвэрлэхэд зөвлөмж өгөх.	- Монгол орны нутаг дэвсгэрт ялгагдсан стратиграфийн нэгжийг баталгаажуулах, - Олон улсад дүйцүүлэх, - Түүнд Монгол Улсыг төлөөлөх эрх бүхий мэргэжлийн бөгөөд байнгын үйл ажиллагаатай байх.	- УТХ-өөр гүйцэтгэх геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, тэдгээртэй адилтгах бусад судалгааны ажлын төсөл, төсвийн тодотгол, үр дүнгийн тайлан, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ГСА-д хэрэглэх нормын төслийг хэлэлцэж, зөвлөмж, дүгнэлт гаргана; - Геологийн судалгааны төсөл, тайлан, ажлын арга, аргачлал, ангилал, түүнд тавигдах шаардлага, заавар, зөвлөмж, дүрэм, журмын төслийг хэлэлцэж, зөвлөмж, дүгнэлт гаргана;

Эх сурвалж: УУХҮС-ын 2015 оны 108, 2022 оны 87 дугаар тушаал, РЗ, МСК, ЭБМЗ-ийн дүрэм, журам.

Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналтын үр нөлөө хангалтгүйгээс Геологийн бодлогын газар болон Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны эрсдэлийг удирдлага хангалтгүй байна.

1.25. АМТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ” гэж заасныг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хасаж 10 дугаар зүйлийн 10.1.19-т “Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ” гэж өөрчлөн баталсан байна.

• Мөн Засгийн газрын 2018 оны 370 дугаар тогтоолоор баталсан “УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4.3-т “геологи, уул уурхайн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулах”, 3.3.5-д “...хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж...” гэж, 2020 оны 105 дугаар тогтоолоор баталсан “УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.5.7.1-т “хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах”, 3.3.7-д “...төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж...” гэж заажээ.

1.26. Гэвч 2018-2022, 2024 онд УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын хэрэгжилтэд тухайлсан төлөвлөгөөт шалгалтыг хийгээгүй байна. Харин 2023 онд УУХҮЯ-ны СХГ/УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын хэрэгжилтэд/, ХШҮДАГ /ҮГА-ны үйл ажиллагаанд/-аас тус тус шалгалт хийсэн байна. Үүнд:

• СХГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тухай” 06-00/008 тоот удирдамжийн дагуу шалгалтыг 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд хийж, тайланг 06 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж УУХҮЯ, ҮГА болон ААНБ-уудад цаашид авах арга хэмжээний 13 саналыг тусгасан байна. Гэвч дээрх тайланг тодорхойгүй шалтгаанаар 6 сарын дараа буюу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж ГБГ-ын дарга, ҮГА-ны дарга нарт дараах үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг даалгажээ. Үүнд:

- Геологийн даалгавар болон гэрээний хугацаа нь дууссан 2019-2023 онуудын нийт 55 төслийн оролцогч талуудад гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах /ЛБГ, УГА)
- Сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжүүдийн төслийн багийг тогтвортой ажиллуулах талаар хяналт тавьж ажиллах (УГА) гэж даалгасан одоог хүртэл даалгаврын хэрэгжилтийг эргэн танилцуулаагүй байна.

- УУХҮС-ын 2023 оны А/311 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ХШҮДАГ-аас 10 дугаар сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд УГА-ны 2020-2023 оны үйл ажиллагаанд шалгалт хийж, тайланг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр УГА-нд хүргүүлсэн байна. Шалгалтын тайланд 24 зөвлөмж тусгаснаас 12 нь УТХ-өөр гүйцэтгэж буй ажлын ХАА, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтай холбоотой байсан бөгөөд УГА биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/384 тоот албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн ч 5 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.27. 2018-2021 онд УУХҮЯ-ны ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу 104, 2022-2023 онд УГА-ны даргын удирдамжийн дагуу 53, нийт 157 (давхардсан тоогоор) ажилд хээрийн шуурхай хяналтыг хэрэгжүүлсэн ч ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хурлаар 2 ажлын тайланг буцааж, 7 ажлын үр дүнгийн тайланг засвартай хүлээн авсан нь шуурхай хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

Үндэсний геологийн алба нь Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакцтай нууцлалын гэрээ байгуулаагүйгээс геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээлэл алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

1.28. Монголын стратиграфийн комисс (цаашид МСК) нь АМГТГ-ын 2017 оны А/101³⁵ дүгээр тушаалаар “Монгол орны стратиграфийн тулгуур зүсэлт, формац, группийн ангиллыг дэлхийн стратиграфийн судалгааны түвшинд хүргэх, монгол орны нийт нутгаар төсвийн хөрөнгөөр хийгдэж буй 1:50000 масштабтай зураглалын ажлыг сайжруулах, шинжлэх ухааны бүтээлийг геологийн суурь судалгаанд хэрэгжүүлэх” чиг үүрэгтэй байсан бол чиг үүрэг, бүрэлдэхүүнд 4 удаа өөрчлөлт оруулснаар УГА-ны даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар “Монгол орны нутаг дэвсгэрт ялгагдсан стратиграфийн нэгжийг баталгаажуулах, олон улсад дүйцүүлэх, түүнд Монгол Улсыг төлөөлөх эрх бүхий мэргэжлийн бөгөөд байнгын үйл ажиллагаатай байна” гэж өөрчилсөн байна.

1.29. Улсын зургийн редакц (цаашид РЗ) нь ЭБЭХС-ын 2012 оны 082 дугаар тушаалаар “Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:200000-ны масштабтай Улсын геологийн зургийн иж бүрдлийг зохиох, тайлбар бичгийг үйлдэх, ажлын заавар, жишгийн мөрдөлтөд хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтаар хангах” чиг үүрэгтэй байсан бол чиг үүрэг, бүрэлдэхүүнд 3 удаа өөрчлөлт оруулснаар УГА-ны даргын 2024 оны А/13 дугаар тушаалаар “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохиогдсон геологийн төрөл бүрийн зураг (1:200000-ны масштабтай Улсын геологийн зургийн нэгтгэлд төвлөрнө) тайлбар бичигт хяналт тавих, төсөл хэрэгжүүлэгчид зургийн нэгтгэл, геологийн хил заагийн маргааныг шийдвэрлэхэд зөвлөмж өгөх” үүрэг бүхий орон тооны бус зөвлөл” гэж өөрчилжээ.

1.30. Аудитаар МСК, РЗ-ийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд МСК-ын дүрмийн 2.2, 5.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээлэл алдагдах эрсдэлийг үүсгэж, комиссоос өгсөн санал шүүмж, засвараа эргэж хянахгүйгээр ГСА-ын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. Тухайлбал:

- МСК нь 2021-2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй нь УУХҮС-ын 2019 оны А/73³⁶ дугаар тушаалаар баталсан дүрмийн 5.1, УГА-ны даргын 2021 оны А/22³⁷, 2023 оны

³⁵ АМГТГ-ын 2017 оны 06 дугаар 15-ны өдөр сарын А/101 дүгээр тушаал

³⁶ УУХҮС-ын 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/173 дугаар “Монголын стратиграфийн комисс байгуулах тухай” тушаал

³⁷ УГА-ны даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаар “Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг байгуулах тухай” тушаал

А/04³⁸, А/11³⁹ дүгээр тушаалаар баталсан дүрмийн 5.1-т заасан “...Комисс нь үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн саналыг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Үндэсний геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ” гэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй;

- Комиссын гишүүд нууцлалын гэрээг 2022-2023 онд УГА-тай байгуулаагүй нь УГА-ны даргын 2021 оны А/22, 2023 оны А/04, А/11 дүгээр тушаалаар баталсан дүрмийн 2.2-т заасан “Комиссын бүрэлдэхүүн ажиллах хугацаандаа УГА-тай мэдээлэл нууцлалын гэрээ байгуулсан байх ба комиссын бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш гэрээнд хамаарах заалт 3 жил хүчинтэй үргэлжилнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй;

- РЗ нь 2022-2024 онд ажиллах хугацаандаа УГА-тай мэдээлэл нууцлалын гэрээ байгуулаагүй нь УГА-ын даргын 2021 оны А/32, 2024 оны А/13 дугаар тушаалаар баталсан журмын 2.4-т заасан “Редакцын зөвлөлийн бүрэн бүрэлдэхүүн ажиллах хугацаанд Геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Үндэсний геологийн албатай мэдээлэл нууцлалын гэрээ байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш гэрээнд хамаарах заалт 3 жил хүчинтэй үргэлжилнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй;

- 2018-2023 онд нийт 38 ажилд хяналт хэрэгжүүлснээс хээрийн ажлын явцын 7 тэмдэглэл, 2 илтгэх хуудас байхгүйгээс гүйцэтгэгчид зөвлөн тусалсан, ажлын чанарт эерэг өөрчлөлт гарсан нь нотлогдохгүй;

- 2018-2024 оны эхний хагас жилийн байдлаар 31 ажлыг комиссын хурлаар хэлэлцүүлснээс 8 хуралдааны тэмдэглэлд “...тайланг засварлан буцаан танилцуулах...” гэж тусгасан ч гүйцэтгэгчээс засварыг эргэж танилцуулсан эсэх нь тодорхойгүй буюу баримтгүй байгаа нь ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар чанаргүй тайлан хэлэлцүүлэх эрсдэлийг үүсгэсэн байна. Тухайлбал: “Түдэвтэй-50” ажлыг ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн шийдвэрт “...3. МСК-ийн гаргасан дүгнэлт шаардлага хангахгүй байгаа тул засвар хийсэн тайланд дахин дүгнэлт гаргах, 4. Шинжээчид нэмэлт өөрчлөлт, засвар хийсэн тайланг хүлээн авч дахин дүгнэлт гаргах” гэжээ.

1.31. Мөн салбарын зөвлөх, мэргэшсэн геологичдоос “УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын үр дүн, чанарт бодит хяналт хэрэгжүүлж байна уу? болон “УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах ГСА гүйцэтгэх явцад орон тооны бус зөвлөл болох МСК, РЗ, төрийн захиргааны төв, захиргааны байгууллагын хамтарсан хяналт /суурин болон хээрийн шуурхай/-аар мэргэжил арга зүйн болон зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна уу ? гэсэн 2 асуулт тус бүр 20 хүнээс 13 хүн буюу 65 хувь нь хангалтгүй гэсэн хариултыг өгч, дараах шалтгаан байгааг хэлсэн байна. Үүнд:

- Геологийн судалгааны ажлын үр дүн, чанарын хяналтыг хэн хяналт хийж буйгаас шалтгаалж сул, гол хяналт санхүүжилтийг голлож, судалгааны үр дүнг зөвлөх, хамтран шийдвэрлэх талдаа учир дутагдалтай байна. Шуурхай хяналтын багийн гишүүдийн мэдлэг чадвар дутмагаас хяналт хангалтгүй, хяналтын үр дүн геологийн судалгааны ажлын чанар, үр дүнд нөлөөлөх нөлөө бага, ажлаа мэддэг хүн байх шаардлагатай. Судалгааны ажлын суваг, шурф ихэнхдээ зохиомол хийдэг. Судалгааны ажлын хяналт сул, чанаргүй тайлан гарч байгаа нь сайн геологич байхгүй;

- МСК тоон үзүүлэлтийг нь анхаарахаас бус чанар, үр дүнг болон арга аргачлалын талаар огт анхаардаггүй. Геологи-геофизикийн иж бүрэн судалгааны мэргэжил арга зүйн болон зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй болгох талаар хангалтгүй ажилладаг. МСК нь мэргэжил арга зүйн зөвлөгөөг ховор өгдөг. Хээрийн шуурхай хяналт хангалтгүй байна.

Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.32. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах”

³⁸ УГА-ны даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/04 дүгээр ““Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай” тушаал

³⁹ УГА-ны даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/11 дүгээр ““Монголын стратиграфийн комиссын ажиллах дүрэм, байнгын гишүүдийн бүрэлдэхүүнийг томилох тухай” тушаал

заасны дагуу УУХҮС-ийн 2016 оны 23, 2018 оны А/46, 2021 оны А/25, А/195 дугаар тушаалаар “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-ийг 4 удаа баталсан байна.

1.33. Гэтэл УУХҮС-ийн 2016 оны 23, 2018 оны А/46, 2021 оны А/25, А/195 дугаар тушаалаар баталсан ЭБМЗ-ийн дүрэмд заасан “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаан”-аар хэлэлцүүлэх дараах асуудлуудыг огт хэлэлцэж байгаагүй байна. Үүнд:

• ЭБМЗ-ийн дүрэмд заасан Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцэх “...төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд хэрэглэх нормын төслийг хэлэлцэх...”, “геологийн судалгааны төсөл, тайлан, ажлын арга, аргачлал, ангилал, түүнд тавигдах шаардлага, заавар, зөвлөмж, дүрэм журмын төслийг хэлэлцэх” асуудал, чиглэлийг 54 удаагийн салбар хуралдааны хэлэлцэх асуудал, хурлын дэгт огт тусгаагүйгээс 2018 оноос хойш сүүлийн 6 жилийн хугацаанд судалгааны ажилд хэрэглэх нормын төсөл, холбогдох арга, аргачлал, заавар, дүрэм, журмын төслийг хэлэлцээгүй байна.

1.34. ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл нь 2018 онд 5, 2019 онд 6, 2020 онд 6, 2021 онд 9, 2022 онд 12, 2023 онд 8, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 9 удаа тус тус хурал зохион байгуулж, 1 жилд багадаа 2 сар, ихдээ 5 сар хурал зохион байгуулсан нь ЭБМЗ-ийн дүрмийн 8.1-т “...хуралдаан нь тасралтгүй ажиллагаатай байна...” гэсэн зарчим бүрэн хангагдаагүй байна.

1.35. УУХҮС-ийн 2018 оны А/48, 2019 оны А/14, 2020 оны А/239, 2022 оны А/93, 2024 оны А/36 дугаар тушаалаар ЭБМЗ-ийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийг байгуулж, салбар зөвлөлийн дарга 1, НБД 1, гишүүд дунджаар 14-21 байхаар батлагдсан байна.

Дээрх тушаалаар томилогдсон нийт гишүүдээс ЭБМЗ-ийн дүрмийн 10.2.4-т “Өргөтгөсөн болон салбар зөвлөлийн гишүүдийн төрийн төлөөлөлд геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан албан тушаалтан байна” гэж заасны дагуу 2018-2024 оны хооронд 71.4 - 33.3 хувийг төрийн байгууллагын төлөөлөл, 28.6-66.7 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 9. Геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуултай холбоотой асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн гишүүдийн 2018-2024 оны томилгооны судалгаа

Үзүүлэлт	УУХҮС-ын 2018.02.26- ний өдрийн А/48	УУХҮС-ын 2019.01.21- ний өдрийн А/14	УУХҮС-ын 2020.09.24- ний өдрийн А/239	УУХҮС-ын 2022.05.09- ний өдрийн А/93	УУХҮС-ын 2024.02.05- ний өдрийн А/36
Салбар зөвлөлийн нийт гишүүдийн тоо	14	17	16	15	21
Төрийн төлөөлөл /...төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан албан тушаалтан /	10	9	7	7	7
Төрийн байгууллагын төлөөллийн эзлэх хувь	71.4	52.9	43.8	46.7	33.3
Төрийн бус байгууллагын төлөөлөл /хамаарах салбарын зөвлөл, мэргэшсэн мэргэжилтэн/	4	8	9	8	14
Төрийн бус байгууллагын төлөөллийн эзлэх хувь	28.6	47.1	56.3	53.3	66.7

Эх сурвалж: УУХҮС-ийн 2018 оны А/48, 2019 оны А/14, 2020 оны А/239, 2022 оны А/93, 2024 оны А/36 дугаар тушаал

1.36. Энэ нь 2018 оноос 2021 оны хооронд ЭБМЗ-ийн дүрмийг 3 удаа батлахдаа “Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц” хэсэгт агуулгын дараах өөрчлөлтийг оруулсан нь тухайн салбарт мэргэжлийн зөвлөл, мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжлийн түвшинд санал, дүгнэлт гаргах нөхцөлийг бий болгосон байна. Үүнд:

- УУХҮС-ын 2018 оны А/46 дугаар тушаалаар баталсан ЭБМЗ-ийн дүрмийн 3.5-д “Зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллага, мэргэжлийн инженерүүдийн холбоод болон итгэмжлэгдсэн лабораторийн төлөөлөл байж болох бөгөөд Төрийн захиргааны албан хаагчийн эзлэх хувь олонх байна” гэж;
- УУХҮС-ын 2021 оны А/25 дугаар, А/195 дугаар тушаалаар баталсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 11.2.3 болон 10.2.3-т “...салбар зөвлөлийн гишүүдийн тавиас доошгүй хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл байх...” гэж өөрчилсөн нь төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.37. ЭБМЗ-ийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийн гишүүн тус бүрийг геологийн салбарын зөвлөх, мэргэшсэн эсэхэд дүн шинжилгээ хийхэд 2018 онд 42.9, 2019 онд 47.1, 2020 онд 37.5, 2022 онд 66.7 хувь нь салбарын зөвлөх, мэргэшсэн мэргэжилтэн байгаа нь ЭБМЗ-ийн дүрмийн 10.2.2-т “Хамаарах салбарын зөвлөх, мэргэшсэн мэргэжилтэн байх” гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй ч 2024 онд 21 гишүүнээс 18 гишүүн буюу 85.7 хувь нь зөвлөх, мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн нь 2018 оноос 42.8 хувиар нэмэгдсэн байна.

1.38. “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийн зарим гишүүд нь ЭБМЗ-ийн дүрмийн 10.2.1-т “Зөвлөлийн гишүүд нь геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тос зэрэг тухайн салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах чиглэлийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 10 жилээс доошгүй хугацаанд ажилласан туршлагатай байх” гэсэн шаардлагыг 4 гишүүн хангаагүй байна. Тухайлбал:

- 2018 оны салбар зөвлөлийн 1 гишүүн нь тухайн салбарт ажилласан жил нь 2024 оны байдлаар 12 жил буюу 2018 онд 6 жилтэй;
- 2022 оны салбар зөвлөлийн 1 гишүүн нь тухайн салбарт ажилласан жил нь 2024 оны байдлаар 11 жил буюу 2022 онд 9 жилтэй;
- 2024 оны салбар зөвлөлийн 1 гишүүн нь тухайн салбарт ажилласан жил нь 2024 оны байдлаар 3.5 жилтэй, 1 гишүүн нь 2024 оны байдлаар 1.6 жилтэй байна.

1.39. Харин ЭБМЗ-ийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийн зарим гишүүдийн зөвлөлийн хуралд суусан ирцийн бүртгэлгүй, хурлын дэг нь батлагдаагүй, зөвлөлийн зарим гишүүд (төрийн байгууллагаас томилогдсон) хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй хүсэлтийг бичгээр мэдэгдээгүй, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаагүй байна. Тухайлбал:

1. 2022 онд Салбар зөвлөлийн гишүүдийн хуралд суусан ирцийн бүртгэл⁴⁰ байхгүй байхад ЭБМЗ-ийн Геологийн судалгаа хэлэлцэх салбар хуралдааны гишүүдийн 2023 оны эхний хагас жилийн цалинг тооцоход шаардлагатай ирцийн бүртгэлийн нэгтгэлийг 2023.06.09-ны өдөр гаргасан⁴¹ тухайн өдрийн хурал хэдэн хувийн ирцтэй явагдсан нь тодорхойгүй нь ЭБМЗ-ийн дүрмийн 5.4-т “Тухайн хуралдаанд оролцох зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь ирсэн тохиолдолд хуралдааны ирцийг бүрдсэнд тооцож хуралдааныг зохион байгуулна”, гэж заасныг нотлох баримтгүй;
2. Салбар зөвлөлийн төрийн байгууллагаас томилогдсон зарим гишүүд нь 2018 оны 3, 2019 оны 6, 2020 онд 3, 2021 онд 5, 2022 онд 4, 2024 онд 1 удаагийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй хүсэлтийг бичгээр мэдэгдээгүй, тухайн хуралд суугаагүй гишүүнийг төлөөлж хуралд суусан харьяалах нэгжийн мэргэжилтэн нь хэнийг төлөөлж сууж байгаа нь тодорхойгүй зэрэг нь ЭБМЗ-ийн дүрмийн⁴² 5.5-т Төрийн байгууллагаас томилогдсон Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Зөвлөлийн дарга, салбар хуралдааны даргад бичгээр мэдэгдэж, харьяалах нэгжийн мэргэшсэн мэргэжилтнийг хуралдаанд санал өгөх эрхтэйгээр

⁴⁰ ЭБМЗ-ийн 2018 оны дүрмийн 5.4-т Тухайн хуралдаанд оролцох зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь ирсэн тохиолдолд хуралдааны ирцийг бүрдсэнд тооцож хуралдааныг зохион байгуулна.

⁴¹ ЭБМЗ-ийн Геологийн судалгаа хэлэлцэх салбар хуралдааны гишүүдийн 2023 оны эхний хагас жилийн цалинг тооцоход үр шаардлагатай ирцийн бүртгэл /УУХҮС-ын 2022 оны А/93 тушаалаар батлагдсан бүрэлдэхүүн/-ийн нэгтгэлтэй Танилцсан: ЭБМЗ-ийн орлогч дарга Л.Баярмандал, Хянасан: ЭБМЗ-ийн салбар хуралдааны дарга Б.Уянга, Бүртгэл гаргасан. Салбар хуралдааны нарийн бичгийн дарга Э.Мөнх-ирээдүй... гэж баталгаажуулсан.

⁴² УУХҮС-ын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар баталсан Эрдэм баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 5.5 дахь заалт

оролцуулж болно”, дүрмийн⁴³ 11.4.2-т “Зөвлөлийн хуралдаанд тогтол оролцож, зөвлөлийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй;
3. Салбар зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд суусан 10 гишүүн, 2021 оны 3 сар, 6 сарын хуралдаанд цахимаар оролцсон гишүүд, 2022 оны 6 сараас 2023 оны 4 сарын хооронд хуралдаанд суусан бүх гишүүн нь “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаагүй (нотлох баримтгүй) нь ЭБМЗ-ийн дүрмийн 7.6-д “Зөвлөлийн гишүүд нь хэлэлцэж байгаа асуудалтай ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ талаараа хуралдаан даргалагчид бичгээ урьдчилан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд хуралдаан даргалагч түүнийг тухайн асуудлыг хэлэлцэх хуралдаанд оролцуулахгүй ба хэрэв хуралдаан даргалагч ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааныг удирдах эрхээ олонхын саналаар аль нэг гишүүнд шилжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгоогүй;

4. ЭБМЗ-ийн дүрмийн 1.4-т Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ... гэж заасан ч салбар зөвлөлийн хуралдааны дэг батлагдаагүй 2018 онд 5, 2023 онд 4 удаагийн хуралдааны дэг нь батлагдаагүй, 2019 онд 3, 2021 онд 2, 2024 онд 1 удаагийн хуралдааны дэг нь байхгүй байна;

5. УУХҮС-ын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/36 дугаар тушаалаар байгуулагдсан салбар зөвлөл нь 2024 оны эхний хагас жилд 9 удаа хуралдсан бөгөөд 2024 оны 3 дугаар сард 2 удаагийн хурлын дэгийг 2023 оноор баталсан нь алдаатай, ЭБМЗ-ийн дарга, салбар зөвлөлийн НБД нарын ажилд хандах хандлага хайнга байна. Тухайлбал: Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хурлын дэг /ЭБМЗ-ийн дарга М.Мэндбаяр баталсан/, Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн УТХ-2024-05 дугаар хурлын дэг (ЭБМЗ-ийн дарга М.Мэндбаяр баталсан) байна.

1.40. Дээрх байдал нь Зөвлөлийн зарим гишүүд нь хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан тухайн гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгийг илэрхийлэх баримтгүй нь тухайн тайланг хэлэлцэхэд нөлөөлөл үүсэх эрсдэлтэй байна.

1.41. УТХ-өөр 2018-2023 онд хэрэгжиж дууссан 54 төслийг ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хурлаар хэлэлцүүлснээс 29 ажлын гэрээг дүгнэж, 2024 эхний хагас жилд тухайн ажлын үр дүнгийн тайлан хүлээн авах хугацаанаас 1-3 жилийн хугацаа өнгөрсөн байхад 21⁴⁴ төслийг салбар зөвлөлийн хуралдааны дэгт хэлэлцэхээр тусгасан, гэрээ дүгнэх шатанд 2 (Түдэвтэй-50, БӨМ-Алт-2019), засвар хийгдэхээр буцаасан 2 (Модот толгой-50, ДА геоэкологи-2020) ажил байна.

Хүснэгт 10. ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн ажлын нэгтгэл

№	Төслийн нэр төрөл	Нийт төсөл	ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцсэн			
			Гэрээ дүгнэсэн	Гэрээ дүгнэх шатанд явж байгаа	Хуралдааны дэгт хэлэлцэхээр тусгасан	Засвар хийлгэхээр буцаасан
1	1:50000 геологийн зураглал, ерөнхий эрэл	56	20	2	12	1
2	Ашигт малтмалын судалгаа	8	2	1	2	-
3	Геофизикийн судалгаа	3	-	-	1	-
4	Эрэл үнэлгээ	4	1	-	2	-
5	Гео.ийн бусад төрлийн суурь судалгаа	12	3	-	2	-
6	Геохимийн судалгаа	2	-	-	1	-
7	Геоэкологийн судалгаа	4	2	-	1	1
8	Нийт төсөл	89	28	3	21	2

Эх сурвалж: ЭБМЗ-ийн дүгнэлт, УУХҮС-ын тушаал

1.42. УУХҮЯ-аас 2021-2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаар УТХ-өөр гүйцэтгэж буй ГСА-ын хэрэгжүүлж буй төсөл, талбайн солбицлын мэдээллийг АМГТГ-т хүргүүлээгүй нь АМТХ 11¹ дүгээр зүйлийн 11¹.1.5-т “энэ хуулийн 11.1.26²-д заасан талбайн мэдээллийг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнд тогтоосон

⁴³ УУХҮС-ын 2021 оны А/195 дугаар тушаалаар баталсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм

⁴⁴ Дэлгэрэнгүйг хавсралт 3.

ашигт малтмалын нөөц, баялаг, эрдсийн хуримтлалтай эсэхийг нягталж, талбайн геологийн мэдээллийг бэлтгэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.43. УУХҮЯ-аас АМГТГ-т 2018-2024 оны эхний хагас жилд УТХ-өөр хэрэгжүүлж байгаа 1:50000 масштабтай геологийн зураглал, эрэл үнэлгээний талбайн солбицлын мэдээллийг албан бичгээр хүргүүлж байгаагүйгээс мөн онуудад УТХ-өөр ГСА хэрэгжүүлж байсан, үр дүнгийн тайлан гараагүй талбайд хайгуулын 11 тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Хүснэгт 11. УТХ-өөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн ГСА-ын үр дүнгийн тайлан гараагүй талбайд Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон судалгаа

№	УТХ-өөр хэрэгжүүлж буй дуусаагүй ажлын төслийн нэр, хугацаа			ГСА-ын хэрэгжүүлж буй талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талбайн давхцал				
	Төслийн нэр	Огноо	Талбай га	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн нэр	Олгосон	Дуусах	Талбай га
1	Хайлааст уул	2014-2018	708,000.0	20103	Булдруу	10/29/2014	10/29/2026	102.5
2	Чандмань уул	2014-2018	670,800.0	21826	Хадат толгой-1	2/16/2015	2/16/2027	1,791.2
3	Чандмань уул	2014-2018	670,800.0	21666	Хүрэнцав	7/27/2017	7/27/2026	14,487.2
4	Номгоны нуруу	2017-2020	302,887.0	20470	Туул	9/25/2017	11/29/2024	11,138.5
5	Номгоны нуруу	2017-2020	302,887.0	20205	Бага үүц	9/26/2017	9/26/2026	3,003.2
6	Их хараат уул	2020-2023	317,966.0	19571	Хүрэн	3/12/2021	3/12/2027	3,543.7
7	Загал уул	2021-2024	335,420.0	21973	Овоот	7/8/2021	7/8/2024	913.5
8	Ханхар уул	2022-2025	238,617.0	20700	Баян уул	11/8/2022	11/8/2025	21,451.1
9	Ханхар уул	2022-2025	238,617.0	20883	Өндөр	11/8/2022	11/8/2025	7,521.1
10	Ханхар уул	2022-2025	238,617.0	16010	Баян	11/8/2022	11/8/2025	1,033.0
11	Загал уул	2021-2024	335,420.0	19644	Хулд	12/22/2023	12/22/2026	860.5
Нийт талбай			2,573,690.0	Нийт олгосон талбай				65,845.5

Эх сурвалж: АМГТГ-ын мэдээлэл

БҮЛЭГ 2. ГЕОЛОГИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨСВИЙН НОРМЫН ЛАВЛАХ НЬ ӨНӨӨГИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БАЙНА.

Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах 1988 онд баталсан бөгөөд өнөөгийн шаардлагыг хангахгүй, 1 км.кв-д хийгдэх ажлын өртөг болон зардлын хэт ялгааг үүсгэж байна.

2.1. СЭЗС, ҮХС-ын 2001 оны 187/76 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг төлөвлөх санхүүжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих журам”-ын 2.5⁴⁵-т “Геологийн судалгааны ажлын төсөл төсөв зохиоход хэрэглэгдэх “Геологи, хайгуулын ажлын төсвийн нормын лавлах”, “Геологи хайгуулын ажилд хэрэглэгдэх ... нэгдсэн норм”-д өөрчлөлт оруулах ... баталж мөрдүүлнэ” гэж заасан ч өнөөдрийг хүртэл боловсруулж, батлуулаагүй байна. Тухайлбал:

• УУХҮЯ-ны ТНБ-ын даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан “Тендерийн Үнэлгээний хорооны 2018 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн хурлын тэмдэглэлд “... 2016, 2017 онд 1 км.кв-ын 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын талбайн дундаж өртөг 201.077 төгрөг байсан бол одоо 205.000 төгрөг болгон 4000 төгрөгөөр нэмэгдүүлсэн, ...ер нь бол тогтсон норм, нормчлол байдаггүй (ТҮХ-ний НБД Ш.Эрдэнэцэцэг) гэж дурдсан байна.

2.2. Журмын 2.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс өнөөдрийг хүртэл (тухайн үеийн нэршлээр) БНМАУ-ын Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яамны сайдын 1988 оны 329 дүгээр тушаалаар батлагдсан Геологи үйлдвэр шинжилгээний институтийн эдийн засгийн сектороос боловсруулсан “Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлахыг ашиглаж байгаа гэх боловч 2018-2024 оны хооронд тус лавлахаар ГСА-ын төсөвт өртгийг хэрхэн тооцож гаргасан нотлох баримтгүй байна.

• УУХҮС-ын 2020 оны А-254 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4⁴⁶-ийн 2.4.4-т “2.4.2, 2.4.3-т заасан суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлтийг эдийн засгийн үндэслэлтэй хийх нөхцөлийг бүрдүүлж үнэлгээний суурь түвшинг тогтоох, 2.5.4⁴⁷-ын 2.5.4.1-т Геологи, эрдэс баялгийн чиглэлээр улсын төсвөөс санхүүжих суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, төлөвлөгөөнд төсөөлөгдөх зардлыг эдийн засгийн үндэслэлтэй тогтоох, мөрдүүлэх...” гэж заасан байна.

2.3. УТХ-өөр санхүүжүүлэх геологийн судалгааны ажлын төсөвт өртгийг ямар норм, аргачлалыг үндэслэн тооцоолсон нь тодорхойгүйгээс гүйцэтгэгч бүрийн геологийн судалгаа, зураглалын ажилд зарцуулагдсан 1км² талбайн өртөг болон зардал үнийн хэт ялгаатай байна. Дээрх байдал нь 1988 оны “Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах өнөөгийн шаардлагыг хангахгүй болсныг илтгэж байна. Тухайлбал:

• 1 км.кв талбайд зарцуулах зардлын өртөг 2014-2018 онд 193.4 мянган төгрөг, 2019-2020 онд 302.4 мянган төгрөг буюу өмнөх жилүүдээс 40 хувь, 2021-2022 онд 455.2 мянган төгрөг буюу 58 хувиар өссөн байна. Үүнд:

• 2014-2018 онд эхэлсэн 24 ажилд 1км² талбайд зарцуулах зардал 186.0-198.0 мянган төгрөг буюу дунджаар 193.4 мянган төгрөг байгаа нь үнийн хөөргөдөл, ханшны уналт буюу инфляц, ажиллах хүчний хомсдолын нөлөөлөл бага, 1км.кв талбайд зарцуулах өртөг нь 5% хэлбэлзэлтэй;

• 2019-2020 онд эхэлсэн 22 ажил 1км² талбайд 285.5-319.2 мянган төгрөг буюу дунджаар 302.4 мянган төгрөг байгаа нь өмнөх жилүүдийн төсвөөс 40 хувиар өссөн,

⁴⁵2.5.Геологийн судалгааны ажлын төсөл төсөв зохиоход хэрэглэгдэх “Геологи, хайгуулын ажлын төсвийн нормын лавлах”-ын цаг зарцуулалт, “Геологи хайгуулын ажилд хэрэглэгдэх гол нэр төрлийн материалын зарцуулалт, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, ээлжийн тоноглол, багаж хэрэгслийн элэгдлийн нэгдсэн норм”-д өөрчлөлт оруулах асуудлыг төсвийн төсөл боловсруулахаас өмнө Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар нь Санхүү, эдийн засгийн яамтай тохиролцож, АМХЭГ-ын Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцэн протоколыг үндэслэн АМХЭГ-ын даргын тушаалаар баталж мөрдүүлнэ.

⁴⁶ Үйл ажиллагааны стратегийн зорилт

⁴⁷ Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд

- 2021-2022 онд эхэлсэн 12 ажил 353.6-557.2 мянган төгрөг буюу дунджаар 455.2 мянган төгрөгийн байгаа нь өмнөх жилүүдийн төсвөөс 58 хувиар өссөн байна.

График 2. 2017-2024 оны хооронд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн зардал өссөн ажлуудын 1 км.кв талбайд зарцуулах зардал



- Хээрийн судалгааны ажлын үед геологич хооронд 500 метр зайтайгаар хээрийн маршрут хийх явцад геологич шинээр ашигт малтмал тогтоох дээжлэлт судалгаа, хувирал өөрчлөлт, геологийн хурдас чулуулаг, хил зааг, худаг ус, геоэкологи зэрэг ажиглалт судалгааг талбай дээр гүйцэтгэх 1км.кв-ын ажлын өртөг, зардал нь үнийн хэт ялгаатай байна. Үүнд:

Хүснэгт 12. 2014-2022 онд хооронд эхлэх хэрэгжих зураглалын ажлын 1км² талбайн өртөг, зардал

№	ГСА-ын		1км² өртөг /мян.төг/	Талбай		Зардал /мян.төг/
	Хугацаа	Тоо		Мян.км²	Хувь	
1	2014-2019	4	27.9	24.5	11%	686,428.0
2	2016-2020	8	32.8	29.7	13%	903,620.0
3	2017-2021	6	29.0	22.5	10%	657,666.0
4	2018-2022	6	33.3	22.8	10%	760,718.0
5	2019-2023	10	48.4	52.3	23%	2,449,629.0
6	2020-2024	12	38.9	46.2	20%	1,982,299.0
7	2021-2024	4	47.5	12.9	6%	623,328.0
8	2022-2025	6	62.4	16.6	7%	1,021,787.0
9	Бүгд	56	40.4	227.4	100%	9,085,474.0

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

- 2017-2021 онд хэрэгжсэн 6 төслийн хувьд 22-39.5 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй нь “Шүтээн улаан уул-50” төсөлд 39.5 мянган төгрөг (Гео-эрин ХХК);
- 2018-2022 онд хэрэгжсэн 6 төслийн хувьд 21-46.2 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй нь “Түдэвтэй уул-50” төсөлд 46.2 мянган төгрөг (Алтайн нэгдэл ХХК);
- 2019-2022 онд хэрэгжсэн 10 төслийн хувьд 22-91.7 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй “Борзонгийн говь 50” төсөлд 88.7 мянган төгрөг (Дипирамид ХХК), “Ширээт уул-50” төсөлд 91.76 мянган төгрөг (Алтайн нэгдэл ХХК);
- 2020-2024 онд хэрэгжсэн 12 төслийн хувьд 18-58.1 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй нь “Үнэгт уул-50” төсөлд 52.0 мянган төгрөг (Монгол Алт ХХК), “Торлог уул 50” төсөлд 58.1 мянган төгрөг (Геологийн судалгааны төв ТӨҮГ);
- 2021-2024 онд хэрэгжсэн 4 төслийн хувьд 42.5-55 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй нь “Ямаат уул-50” төсөлд 55 мянган төгрөг (Литос майнинг ХХК);
- 2022-2025 онд хэрэгжүүлж буй 6 төслийн хувьд 42.9-111.9 мянган төгрөг байна. Хамгийн өндөр дүнтэй нь “Мөст-уул-50” төсөлд 111.9 мянган төгрөг (Монгол Алт ХХК)-ийн өртөг зардалтайгаар ажлыг хийж гүйцэтгэж байгаа нь тухайн жилүүдэд зэрэг эхэлсэн төслүүдийн үнийн дүнгээс 2-3 дахин их байна.

- 1 ширхэг шлих⁴⁸ дээж авах тоог 1км.кв-д ноогдох шлих сорьцын тоотой харьцуулахад тухайн жилүүдэд зэрэг эхэлсэн төслүүдийн шлихийн сорьцын болон нийт шлихийн сорьцын 1км.кв талбайд ноогдох дунджаас 1-3 дахин бага байгаа нь шинээр ашигт малтмалуудын сарнилын хүрээ, шороон илрэл илрэх боломж хумигдах цаашилбал судалгааны ажил дутуу, төслийн үр дүн, чанарт нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 13. ГСА-ын явцад 1 ширхэг шлих сорьц авч угаах өртөг болон 1км.кв талбайд ноогдох сорьцын тоо

№	ГСА-ын		Талбай мян.км2	1 ширхэг шлих мян.төг	Дээжийн тоо		Зардал сая.төг
	Хугацаа	Тоо			Ширхэг	Дээжийн тоо 1км.кв	
1	2014-2019	4	24.45	11.3	17,095	0.71	198.1
2	2016-2020	8	29.66	12.6	12,215	0.41	122.9
3	2017-2021	6	22.54	11.3	16,261	0.77	173.0
4	2018-2022	6	22.80	12.8	15,355	0.66	205.1
5	2019-2023	10	52.30	16.8	33,724	0.62	533.2
6	2020-2024	12	46.17	16.2	25,826	0.58	452.0
7	2021-2024	4	12.91	14.1	25,082	0.71	136.0
8	2022-2025	6	16.56	20.5	9,347	0.57	214.8
9	Бүгд	56	227.38	14.8	154,905	0.61	2,035.0

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл


- 2014-2019 онд хэрэгжсэн 4 төслүүдийн хувьд 0.54-0.81 ширхэг сорьц буюу дундаж 0.67,
- 2016-2020 онд хэрэгжсэн 8 төслийн хувьд 0.19-0.81 ширхэг сорьц байна. Хамгийн бага сорьц “Худгийн нуруу-50” төсөл 0.19 ширхэг (Алтайн нэгдэл ХХК), “Цайлангийн нуруу-50” төсөл 0.24 ширхэг сорьц (Дипирамид ХХК);
- 2017-2021 онд хэрэгжсэн 6 төслийн хувьд “Тээгийн гол-50” төсөл 0.45 ширхэг (Алхчулуу ХХК);
- 2018-2021 онд хэрэгжсэн 6 төслийн хувьд “Бүрэхтэй уул-50” төсөл 0.44 ширхэг /Эрэн чулуу ХХК/, “Модот толгой-50” төсөл 0.47 ширхэг сорьц (Дипирамид ХХК);
- 2019-2022 онд хэрэгжсэн 10 төслийн хувьд 0.36-1.1 ширхэг сорьц байна. Хамгийн бага нь “Ширээт уул 50” төсөл 0.36 ширхэг (Алтайн нэгдэл ХХК), “Алагбаян-50” төсөл 0.4 ширхэг (Мадерланд ХХК);
- 2020-2024 онд хэрэгжсэн 12 төслийн хувьд 0.13-0.87 ширхэг сорьц байна. Хамгийн бага нь “Үнэгт уул-50” төсөл 0.13 ширхэг /Монгол Алт ХХК/, “Торлог уул-50” төсөл 0.31 ширхэг (Геологийн судалгааны төв ТӨҮГ), “Их бэрх уул-50” төсөл 0.38 ширхэг (Найманбат ХХК);
- 2021-2024 онд хэрэгжсэн 4 төслийн хувьд 0.34-1.23 ширхэг сорьц байна. Хамгийн бага нь “Бөөн хөх уул-50” төсөл 0.34 ширхэг (Арвинмайнинг ХХК);
- 2022-2025 онд хэрэгжсэн 6 төслийн хувьд 0.19-0.91 ширхэг сорьц байна. Хамгийн бага нь “Мөст-уул-50” төсөл 0.19 ширхэг (Монгол Алт ХХК), “Ханхар уул-50” төсөл 0.33 ширхэг (Гео эрэл зураглал ХХК) сорьц 1 км.кв талбайд ноогдож байна.

- Уулын ажлын 1м.куб уулын ажлыг ухах, буцааж булах нөхөн сэргээх зардалд дүн шинжилгээ хийхэд 2014-2025 онд дунджаар 4.4-50.9 мянган төгрөгийн хооронд харилцан адилгүй буюу 11 дахин хэлбэлзэж байна. Тухайлбал:

- Мөн 1м3 уулын ажил хийнэ гэдэг нь хүрз болон жоотуу ашиглаж хад ухахад нэг хүн өдөрт 1м3 ухах боломжтой гэж үзвэл 8.2-25.9 мянган төгрөг;
- Төв суурин газраас хол төсөлд техник аваачиж 1м3 уулын ажил хийлгэх нь тээврийн зардал, ажиллах хүн хүч, түлш шатахуун зэргээс хамаарч 8.2-25.9 мянган төгрөгөөр хийх нь эргэлзээтэй;
- Захиалагчаас нийт төсөлд дурдагдсан уулын ажлын гүйцэтгэлийг ямар норм, нормчлолыг үндэслэн хяналт тавьж байгаа нь тодорхойгүй байна.

⁴⁸ Шлихийн сорьцлолтын зардал, нэзгийн талбайд тархсан жалганы сэвсгэр хурдасны бага зөөгдөлтэй, ул чулууны дээд талын 2 үеийн доод талаас 80-100 см хүртэл ухаж 20-25 кг шороог авч усаар угааж зайлах байдлаар хүнд эрдсийг ялган авч эрдсүүдийг шинжлэн судалдаг.

График 3. ГСА-аар суваг болон шурф ухах, буцааж булах 1м.куб-ийн өртөг, зардал /мян.төг/



- Суурин боловсруулалтын ажлын 1 км.кв талбайд ноогдох хүн/өдөрт дүн шинжилгээ хийхэд 2014-2018 онд 30.0-34.0 мянган төгрөгийн цалинтай байсан бол 2019-2025 онд 45.0-62.0 мянган төгрөг болж өссөн байна. Тухайлбал:

- Суурин боловсруулалтын 1км.кв талбайд зарцуулах цалин 2014-2018 онд хэрэгжсэн 24 төсөлд 30.0-34.0 мянган төгрөг байсан бол 2019-2025 онд 45.0-62.0 мянган төгрөг болж өссөн /2019-2022 онд Татах хүч ХХК-ийн хэрэгжүүлсэн “Хайрхан овоо-50” ажил 2 хүн/өдөр/;
- Харин 2022-2025 онд хэрэгжсэн Эрдэнэс даян уул ХХК-ийн хэрэгжүүлсэн “Овоот шар-50” ажил 3.4 хүн/өдөр, “Гео эрэл зураглал ХХК”-ийн хэрэгжүүлсэн “Ханхар уул-50” ажилд 3 хүн/өдөр байгаа нь бусад адил төрлийн ажлуудаас 2-3 дахин их хугацааг суурин боловсруулалтад зарцуулсан байна.

Хүснэгт 14. ГСА-уудын суурин боловсруулалтын хугацаа, нэгжийн өртөгийн харьцуулалт

Эхлэх-дуусах	2022-2025	2020-2023	2020-2023	2020-2023
Төслийн нэр	Овоот шар-50	Улаангом-50	Уушгийн улаан-50	Торлог уул-50
Төсөл хэрэгжүүлэгч	Эрдэс даян уул ХХК	Идэр нумт ХХК	Гео-Орон ХХК	ГСТ ТӨҮГ
Нэгжийн өртөг /төгрөг/	50,000.0	32,126.0	43,900.0	60,000.0
Хүн/өдөр	7,605	4,240	3,360	3,634
Нийт зардал /сая.төг/	380.0	136.0	148.0	218.0
Талбайн хэмжээ км2	2,259	2,276	2,374	2,805
1км2 ноогдох хүн.өдөр	3.4	1.9	1.4	1.3
УБ-аас талбай хүртэлх зай км	1,800	1,500	1,500	1,450

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

- Тээврийн зардал, нэгжийн өртөг нь гүйцэтгэх үүрэг чиглэлээрээ хүн тээвэр, үйлдвэрийн тээвэр, ачаа тээвэр гэсэн байдлаар ангилагдана. Судалгааны ажил хэрэгжсэн жилүүдэд А92 бензин болон Дизель түлшний үнийг харьцуулахад 1км.кв талбайд ноогдох тээврийн зардал харилцан адилгүй байна.

Хүснэгт 15. ГСА-ын 1 км.кв талбайд ноогдох тээврийн зардал болон түлш шатахууны үнэ

№	Төслийн		УБ хотоос талбай хүртэлх дундаж зай /км/	1км2 талбайд тээврийн зардал /мян.төг/	Тээврийн зардал /сая.төг/	Шатахууны үнэ /төгрөг/	
	Хугацаа	Тоо				А92	Дизель
1	2014-2019	4	1013	23.8	588	1660	1750
2	2016-2020	8	609	18.2	534	1650	1800
3	2017-2021	6	678	21.0	473	1700	1850
4	2018-2022	6	587	17.9	419	1750	2020
5	2019-2023	10	556	22.8	1,014	1840	2500
6	2020-2024	12	912	31.2	1,453	2300	2600
7	2021-2024	4	625	23.7	302	2500	2750
8	2022-2025	6	908	48.7	762	2750	3750
9	Бүгд	56	731	26.1	5,544	-	-

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

Хүснэгтээс харахад 1км.кв талбайд ноогдох тээврийн зардал нь түлшний үнийн өсөлтөөс шууд хамааралтай байх боломжтой байна. Гэвч энэ нь ажлуудын хувьд харилцан адилгүй байна.

Тухайлбал 2022-2025 онд хэрэгжих нэг районд зэрэгцээ хоёр ажлын харьцуулахад “Ханхар Уул-50” ажлын тээврийн зардал 181.6 сая төгрөг буюу 1км.кв талбайд 76.1 мянган төгрөг бол “Баянзүрх Уул-50” ажлын тээврийн зардал 88.1 сая төгрөг буюу 1км.кв талбайд 32.3 мянган төгрөг байна. Гэтэл “Ханхар Уул-50” ажлаас 4 дахин хол зайд хэрэгжиж байгаа “Үүрэг нуур-50” ажлын 1 км.кв талбайд ноогдох тээврийн зардал 23.0 мянган төгрөгөөр бага байна.

Хүснэгт 16. ГСА-ын тээврийн зардлын ялгаатай байдал

Эхэлсэн	2022	2022	2016	2017	2019
Дууссан	2025	2025	2020	2021	2022
Төслийн нэр	Овоот шар-50	Ханхар Уул-50	Норовлин-50	Чулуун хороот-50	Хулд 50
Төсөл хэрэгжүүлэгч	Эрдэс даян уул ХХК	Гео эрэл зураглал ХХК	Их цог өндөр ХХК	Магма майнс ХХК	Дархан мянгадар уул ХХК
Нэгжийн өртөг	50,000.0	48,200.0	30,000.0	35,000.0	45,000.0
Хүн/өдөр	7,605	7,267	4,365	6,980	3,562
Нийт мөнгөн дүн	380,260,063.0	350,269,400.0	130,935,000.0	244,277,826.0	160,272,000.0
Талбайн хэмжээ км ²	2258.7	2386.2	3420.8	5632.0	2910.2
1км ² ноогдох хугацаа	3,367.1	3,045.5	1,275.9	1,239.3	1,223.8
Хотоос талбай хүрэх зай км	1800	300	500	850	400

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

- Томилолтын зардал 2014-2022 онд 1 өдөрт 9.6-14.2 мянган төгрөг буюу дунджаар 11.5 мянган төгрөг байгаа нь Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан суманд тооцох байр /60.0/, хоол /30.0/-ны зардлаас 84.2 хувиар бага байна.

Хүснэгт 17. ГСА-аар хээрийн судалгааны ажлын томилолтын зардал болон 1км² талбайд ноогдох томилолтын хоног

№	Төслийн		1 өдрийн томилолтын зардал /мян.төг/			Өдөр /мян.хоног/	Төсөв /сая төг/
	Хугацаа	Тоо	min	Дундаж	max		
1	2014-2019	4	10.0	11.3	12.0	60.2	677.0
2	2016-2020	8	5.0	10.7	15.0	76.2	773.0
3	2017-2021	6	4.5	9.6	15.0	51.7	556.0
4	2018-2022	6	8.5	10.7	14.0	53.8	521.0
5	2019-2023	10	10.0	11.8	15.0	106.1	1,234.0
6	2020-2024	12	5.0	12.2	15.5	130.6	1,673.0
7	2021-2024	4	10.0	14.2	17.5	40.6	556.0
8	2022-2025	6	10.0	11.9	15.0	46.4	552.0
9	Бүгд	56	4.5	11.5	17.5	565.7	6,541.0

Эх сурвалж: УГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

Томилолтын зардал бага байгаа нь ГСА-ын талбайд ажиллах хүний нөөцийн хомсдолд орох, ажил чанаргүй хийгдэх, томилолтоор ажиллах хоногийн тоог хийсвэрээр өсгөх зэрэг эрсдэл үүсэхээр байна.


2.4. Мөн салбарын зөвлөх, мэргэшсэн геологичдоос “УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажилд хэрэглэх норм нь төслийн төсөвт өртөг зохиох, төслийн гүйцэтгэлийг гаргах зэрэгт шаардлага хангаж байна уу? гэсэн асуулгад 20 хүнээс 18 хүн буюу 90 хувь нь хангалтгүй гэсэн хариултыг өгч, дараах шалтгаан байгааг хэлсэн байна.Үүнд:

• ГСА-ын төсөл төсөв зохиолтод ТНЛ /төсвийн нормын лавлах/-ыг ашигладаггүй, шууд тооцоог чухалчилдаг. УУХҮЯ, ҮГА-д геологийн эдийн засагч мэргэжилтэй боловсон хүчингүй. Судалгааны ажлын ихэнх нь урьд хийгдсэн ордуудыг хуулбарласан байдаг. Судалгааны ажлын төслийн төсвийн өртгийг инфляцтай уялдуулж байх хэрэгтэй. Нормчлолын үнэлгээ бага. Цагийн норм болох ч, төсвийн зардлын бүтцийг шинээр тооцож гаргах хэрэгтэй. Хуучин Төсвийн нормын лавлахаар явж байгаа нь дутагдалтай, Норм, төсвөө үнийн өөрчлөлттэй холбоотойгоор өөрчилж байх, шинэчлэх болсон.

Геологийн судалгааны ажлын санхүүжилтийг тухайн жилийн гүйцэтгэлд үндэслэн олгосон ч геологийн судалгааны ажлын аргачлал, хяналтын зардлаар суутгаж авсан дүнгээс 162.3 сая төгрөгийг журмын дагуу зарцуулаагүй байна.

График 4. Нийт геологийн судалгааны ажлын төрлүүдийн эзлэх хувь

2.5. УТХ-өөр 2018-2024 онд 187,960.5 сая төгрөгийн дүнтэй 89 ажлаас 46,116.2 сая төгрөгийн дүнтэй 22 ажил нь 2014 он, 141,844.3 сая төгрөгийн дүнтэй 67 ажил 2018 оноос эхлэн шинээр хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан бөгөөд үүнээс 2 хувийг 1:50000 геологийн зураглал ерөнхий эрлийн, 22 хувийг ашигт малтмалын, 21 хувийг геофизикийн, 12 хувийг эрэл үнэлгээний, 11 хувийг геологийн бусад төрлийн, 3 хувийг геохимийн, 2 хувийг геоэкологийн судалгааны ажил эзэлж байна.



2.6. 2018-2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 89 ажилд 140,855.0 сая төгрөгийн гүйцэтгэлээс гүйцэтгэгчид 113,472.9 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 18. УТХ-өөр 2018-2024 онд хэрэгжсэн ажлуудын төсөвт өртөг


/сая.төг/

№	Төслийн Ангилал	Төсөл арга хэмжээ		2018-2024 оны		
		Тоо	Хувь	Гэрээний дүн	Нийт гүйцэтгэл	Санхүүжүүлсэн дүн
1	1:50000 геологийн зураглал, ерөнхий эрэл	56	29%	60,570.7	50,053.0	43,515.5
2	Ашигт малтмалын судалгаа	8	22%	41,049.6	36,419.0	30,397.4
3	Геофизикийн судалгаа	3	21%	36,166.1	11,351.0	3,407.6
4	Эрэл үнэлгээ	4	11%	21,081.1	15,837.0	12,641.7
5	Геологийн бусад төрлийн суурь судалгаа	12	11%	20,314.0	19,083.0	16,671.0
6	Геохимийн судалгаа	2	3%	4,532.0	4,196.0	3,265.2
7	Геоэкологийн судалгаа	4	2%	4,246.0	3,916.0	3,575.0
8	Нийт бүгд	89	100	187,960.5	140,855.0	113,472.9

Эх сурвалж: ҮГА-аас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэл

2.7. Тухайлбал 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын 56 төсөл арга хэмжээний хувьд зардлын төрлүүдээр харьцуулалт хийж үзвэл зураглалын ажил 15% буюу 9,085.0, эрлийн маршрутад 0.4% буюу 419.0, шлихийн дээжлэлт 3% буюу 2,033.0, урсгал геохими 580.0 буюу 0.6%, геофизикийн ажилд 3,434.0 буюу 6%, уулын ажилд 1,346.0 буюу 2%, лабораторийн зардалд 8,350.0 сая.төг буюу 14%-ийг мэдээлэл олж авах үндсэн үйл ажиллагаанд зарцуулж байна.

2.8. Өөрөөр хэлбэл нийт зардлын 42% буюу 25,248.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа буюу геологийн мэдээлэл цуглуулж авах зардал болж байна. Бусад үйл ажиллагааны зардлууд болох суурин боловсруулалт 11,169.0 буюу 18%, тээвэр 5,544.0 буюу 9%, томилолт 6,580.0 буюу 11%, бусад төрлийн зардал 12,029.0 буюу 20%-ийг тус тус эзэлж байна.



2.9. ГСА-ын аргачлал, хяналтын зардлыг төвлөрүүлэх, төвлөрүүлсэн орлогыг зарцуулах зардлын төсвийг батлах, батлагдсан төсвийн зарцуулалтыг мэдээлэх ажлыг УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан журмын 3.14⁴⁹, 3.15⁵⁰, 3.16⁵¹, 3.17⁵² дахь заалтын дагуу хэрэгжүүлж байсан бол УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар тушаалаар дээрх тушаалыг хүчингүй болгож, шинэчлэгдсэн журмын 3.2.18⁵³, 3.2.19⁵⁴, 3.2.21⁵⁵, 3.2.22⁵⁶, 3.2.23⁵⁷ дахь заалтын дагуу зохицуулахаар тусгажээ.

2.10. УУХҮЯ-ны ТНБД болон УГА-ны даргын 2018-2024 оны тушаалаар аргачлал, хяналтын санхүүжилтээс нийт 4,675.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч аудитад ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтаар 2,492.5 сая төгрөгийг төвлөрүүлж, 1,403.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнийг харуулбал:

Хүснэгт 19. УТХ-өөр 2018-2024 оны аргачлал, хяналтын зардлыг төвлөрүүлэх дүн, бодит орлого болон түүний зарцуулалт

№	Он	Төвлөрүүлэхээр төлөвлөсөн дүн	Орлого	/сая.төг/	
				Зарлага	
1	2018	266.6	268.5	96.5	
2	2019	402.8	498.1	280.2	
3	2020	302.5	525.2	89.5	
4	2021	759.3	486.4	280.2	
5	2022	861.3	366.0	331.3	
6	2023	934.1	348.3	325.3	
7	2024	1,149.1	-	-	
Нийт		4,675.7	2,492.5	1,403.0	

⁴⁹ 3.14. ГСА-ын хэрэгжилтийн явцад төрийн захиргааны төв байгууллагаас томилсон шуурхай хяналтын комисс (цаашид “комисс” гэх) болон Монголын стратиграфийн комисс (цаашид “МСК” гэх)-ын ажлын зардал, мөн хяналт тавихад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, ажлын гүйцэтгэлийг хэмжин шалгах, судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авч лабораторийн шинжилгээ хийлгэх, ГСА-тай холбоотой арга аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх, ГСА-ыг үр дүнтэй гүйцэтгэж, тайлан ЭБМЗ-өөр амжилттай буюу онц сайн хамгаалсан гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зэрэгт зориулан зарцуулах аргачлал, хяналтын зардлыг төсөл тус бүрийн өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2.0 хүртэл хувьтай тэнцэх хөрөнгийг төсөл гүйцэтгэгчээс төрийн захиргааны төв байгууллагын ГСА-ын аргачлал хяналтын зардлын дансанд төвлөрүүлэн зарцуулна.

⁵⁰ 3.15. Төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн холбоод, их, дээд сургууль, эрдэмтэдтэй хамтран салбарын боловсон хүчнийг давтан сургах, дадлагажуулах зорилгоор хээрийн болон танхимын сургалтыг зохион байгуулахад аргачлал хяналтын зардлаас жил бүр тодорхой хэмжээний төсвийг зарцуулна.

⁵¹ 3.16. ГСА-ын тухайн жилийн аргачлал хяналтын зардлын төсвийг төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга батална.

⁵² 3.17. Батлагдсан аргачлал хяналтын зардлын төсөв болон төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн холбогдох баримт, материалыг үндэслэн ГСА-ын аргачлал хяналтын зардлын санхүүжилтийг төрийн захиргааны төв байгууллага хянан олгож зарцуулалтыг төсөл гүйцэтгэгч нарт мэдээнэ.

⁵³ 3.2.18. Шуурхай хяналт, хээрийн материал хүлээн авах, судалгааны ажлын явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх, ГСА-ын арга, аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, хэвлэн нийтлэх, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, хяналтад шаардагдах тоног төхөөрөмж, багаж худалдан авах, МСК, РЗ, ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүд, шинжээчийн зардал, ГСА-ыг чанартай гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардлыг ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

⁵⁴ 3.2.19. Салбарын хүний нөөцийг давтан сургах, дадлагажуулах, танхим, цахим болон хээрийн сургалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөлдөх хурал, зөвлөгөөнд оролцох ажлыг ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

⁵⁵ 3.2.21. УГА нь гүйцэтгэгчийн сар бүрийн ажлын санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэлд тусгасан өөрийн хүчээр хийсэн, НӨАТ тооцсон ажлын 2 хувьтай тэнцэх дүн ГСА-ын аргачлал хяналтын дансанд суутган төвлөрүүлнэ.

⁵⁶ 3.2.22. ГСА-ын аргачлал, хяналтын зардлаас энэ журмын 3.2.18, 3.2.19-д заасан зардлыг санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг УГА-ны дарга баталж, энэ журамд нийцүүлэн Сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүжилтийн эрхийг нээлгэн зарцуулна.

⁵⁷ 3.2.23. УГА нь ГСА-ын аргачлал, хяналтын зардлын санхүүжилтийн тайланг байгууллагын шилэн дансанд тогтмол байршуулж нийтэд мэдээнэ.

Эх сурвалж: УУХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А/88, 2019 оны А/89, 2020 оны А/92, 2021 оны А/41, УГА-ны даргын 2022 оны А-15, 2023 оны А/08, 2024 оны А/07 дугаар тушаал, УУХҮЯ болон УГА-ны 2018-2023 оны санхүүгийн анхан шатны баримт

2.11. Аудитаар аргачлал, хяналтын зардлын 4,675.7 сая төгрөгийн төлөвлөлт болон 1,403.0 сая төгрөгийн зарцуулалтын дүнд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

2018-2021 онд аргачлал, хяналтын зардлаас 1,731.2 сая төгрөгийг 67 (давхардсан тоогоор) төрлийн ажилд зарцуулахаар төлөвлөсөн ба түүний 1,575.5 сая төгрөгийн дүнтэй 55 ажил нь УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан журамд нийцсэн бол 155.7 сая төгрөгийн дүнтэй 12 ажлын төлөвлөлт, төлөвлөгөөнд тусгасан 3 ажилд 53.1 сая төгрөг, төлөвлөгөөнд тусгаагүй 1 ажилд 90 сая төгрөг зарцуулсан нь журмын 3.14, 3.15 дахь заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

- УУХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны А/88 дугаар тушаалаар баталсан “Геологичдын хээрийн сургалт, ажил мэргэжлийн уралдааны зардал”-д 10.0 сая төгрөг, “Магадалшгүй ажлын зардал”-д 2.0 сая төгрөг төлөвлөсөн;
- УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улс, БНХАУ, ОХУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан 17-р хурлыг зохион байгуулах” ажилд 18.0 сая төгрөг, “Хэлэлцүүлэг, хурал зохион байгуулах” ажилд 33.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж “Геологичдын ажил мэргэжлийн уралдааны зардал”-д 11.3 сая төгрөг, “Монгол Улс, БНХАУ, ОХУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан 17-р хурлыг зохион байгуулах” ажилд 16.2 сая төгрөг, төлөвлөгөөнд тусгаагүй “Монгол Улсад геологийн салбар үүсэж хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээ”-ний зардалд 89.9 сая төгрөг зарцуулсан;
- УУХҮЯ-ны ТНБД-ын 2020 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Геологийн салбарын хууль, тогтоомжийн төслийг боловсруулан танилцуулах, санал авах хэлэлцүүлэг”-т 5.0 сая төгрөг төлөвлөсөн;
- УУХҮЯ-ны ТНБД-ын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны үйл ажиллагааны зардал, гишүүдийн цалин”-д 26.7 сая төгрөг төлөвлөж, 25.5 сая төгрөг зарцуулсан байна.

2.12. 2022-2024 онд аргачлал, хяналтын зардлаас 2,944.4 сая төгрөгийг 95 (давхардсан тоогоор) төрлийн ажилд зарцуулахаар төлөвлөж үүнээс 2,579.3 сая төгрөгийн дүнтэй 83 ажил нь УУХҮС-ын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан журамд нийцсэн бол 365.1 сая төгрөгийн дүнтэй 12 ажлын төлөвлөлт, 2022-2023 онд төлөвлөгөөнд тусгасан 35.3 сая төгрөгийн дүнтэй 1 ажил, төлөвлөгөөнд тусгаагүй 1 ажилд 19.7 сая төгрөгийг зарцуулсан нь журмын 3.2.18, 3.2.19, 3.2.22 дахь заалттай нийцээгүй байна.

- УГА-ны даргын 2022 оны А-15 дугаар тушаалаар баталсан “Магадалшгүй ажлын зардал”-д 23.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төлөвлөгөөнд тусгаагүй “Архивын үйлчилгээ”-нд 19.7 сая төгрөг зарцуулсан;
- УГА-ны даргын 2023 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Геологичдын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах зардал”-д 76.2 сая төгрөг, “Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2023 оны гишүүнчлэлийн хураамж”-д 35.2 сая төгрөг, “Магадалшгүй ажлын зардал”-д 9.7 сая төгрөг төлөвлөсөн;
- УГА-ны даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Хээрийн шуурхай хяналтад шаардагдах хувцас (хавар намар өвөл) 39.6 сая төгрөг, “Геологийн судалгааны тайланг архивлахад шаардагдах зардал”-д 18.0 сая төгрөг, “Эрүүл мэндийн шинжилгээ”-нд 14.0 сая төгрөг, “Эм эмнэлгийн хэрэгсэл”-д 14.7 сая төгрөг, “Геологичдын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулах зардал”-д 76.2 сая төгрөг, “Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2024 оны гишүүнчлэлийн хураамж”-д 35.2 сая төгрөг, “Магадалшгүй ажлын зардал”-д 19.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Үндэсний геологийн алба шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

2.13. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1⁵⁸-т хамаарах байгууллага болох УУХҮЯ нь 2018-2019 онд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁵⁹, 6.4⁶⁰-т заасан мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд мэдээлээгүй байна. Үүнд:

- УУХҮЯ нь 2018 оны 6, 2019 оны 10, 2020 оны 01 дүгээр сарын “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-ний мэдээллийг, 2018 оны 4, 2019 оны 1 сарын “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”-ын мэдээллийг тус тус 1 сар хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Харин ҮГА нь 2022-2024 онд хуулийн 6.3⁶¹, 6.4-т заасан мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй байна. Үүнд:

- 2022-2024 онд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3. “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”-ны мэдээллийг системийн тайлангийн нэр хэсэгт байршуулаагүй;
- 2023-2024 онд “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”-ын мэдээллийг огт байршуулаагүй нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁶² дэх заалтыг хэрэгжүүлээгүй;
- Харин “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”-д зарын шинжтэй оруулснаас стандартын дагуу мэдээллийг байршуулаагүй нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6⁶³ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.15. УУХҮЯ-ны ХШҮДАГ⁶⁴-аас 2018-2022 онд Шилэн дансны хөтлөлтөд хяналт хэрэгжүүлээгүй, харин 2023 онд яамны болон харьяа байгууллагуудын 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх Шилэн дансны хөтлөлтийг шалгасан тайланд дээрх зөрчлүүдийг бүрэн илрүүлээгүй нь ТТХ-ийн 4.1.49⁶⁵ “...төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангах ...” чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй байна.

Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэх шаардлага бий болжээ.

2.16. УУХҮС-ын 2018 оны А/19 дугаар тушаалаар “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд 2020 оны А-321 дүгээр тушаалаар дээрх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулжээ.

2.17. НМИТБТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1⁶⁶, 8.4⁶⁷, 8.4.26⁶⁸ дахь заалтад төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана гэж, ЗГҮА-ны 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн 3.2.4.1-т “Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна” гэж заасан.

⁵⁸ 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

⁵⁹ 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

⁶⁰ 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

⁶¹ 6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

⁶² 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

⁶³ 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;

⁶⁴ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

⁶⁵ 4.1.49.“дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг;

⁶⁶ 8.1. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана

⁶⁷ 8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:


⁶⁸ 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;

2.18. УУХҮЯ болон ҮГА-ны мэдээллийн ил тод байдлыг Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шил ажиллагаа”-ны хүрээнд 98 хувийн үнэлгээтэйгээр дүгнэсэн байна.

2.19. ҮГА-ны ГМТ нь үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд ҮГА-ны цахим хуудас <https://ngs.gov.mn/>-аар дамжуулан “Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан”-г хөтөлдөг бөгөөд тус сан нь 6 системээс бүрдэж байна. Үүнд:

1. Геомэдээллийн портал /Иргэд, олон нийтэд зориулсан Геомэдээлэл түгээх портал/

Геомэдээллийг онлайнаар худалдах, захиалах, цахимаар түгээх, растер, вектор өгөгдөл, тайлан, баримт бичгийн мэдээлэл, өгүүлэл, нийтлэл, ном товхимол, судалгааны ажлуудын мэдээлэл нэг дор харагдахаар, мөн хүссэн захиалагч авах боломжтойгоор хөгжүүлэгдсэн Монгеокат, Монгеомин, Монгеокол системүүдийг нэгтгэсэн портал бөгөөд 2 нь нээлттэй, 1 нь зорилтод хэрэглэгчдэд зориулсан байна.



2. Монгеокат /Веб газарзүйн мэдээллийн систем/

Геологи, эрдэс баялгийн судалгааны ажлууд болон олон төрлийн растер, вектор давхаргууд, тэдгээрийн метадата өгөгдөл, газарзүйн байршил, ажлын төрөл, аймаг, бүсээр мэдээллийг хайхаар хөгжүүлэгдсэн олон нийтэд нээлттэй систем бөгөөд аудитаар түүвэрт хамруулсан ажлуудыг нягтлахад гэрээг дүгнэж, архивд тушаагдсан 29 ажлаас 1 ажлын үр дүнгийн мэдээллийг оруулаагүй байна.


Хүснэгт 20. Монгеокат системд үр дүнг оруулаагүй ажил

№	Төслийн нэр	Код	Тайлангийн дугаар	Тушаал гарсан огноо	Архивд тушаасан огноо	Системд үр дүнг оруулсан эсэх
1	Чулуун хороо-50	ЧухХ-50	10060	2022.08.10	2022.10.05	Оруулаагүй

Эх сурвалж: <https://geonet.mris.mn/>

3. Монгеокол систем /Хээрийн судалгааны Геомэдээллийг цуглуулах систем/

Геологийн онцлог тогтоцтой газруудын мэдээллийг мэргэжлийн болон танин мэдэхүйн зориулалттайгаар хөгжүүлсэн олон нийтэд ил мэдээллийн систем бөгөөд 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн 40, 1:200000-ны масштабын нэгтгэлийн 2, сэдэвчилсэн судалгааны 5, геохимийн 1, эрэл үнэлгээний 1 нийт 49 ажлын мэдээллийг оруулсан байна.




4. Монгеомин систем ашигт малтмалын ордын нөөцийн бүртгэл, нэгдсэн тэнцлийг гаргах

Ашигт малтмалын ордын төрөл, тоо, хэмжээг статистик хэлбэрээр гаргах, нөөцийг бүртгэсэн тухай мэдээлэл, нөөцийн тэнцэл гаргах систем гэх боловч уг систем нь зорилтод хэрэглэгчдэд зориулсан (нэвтрэх нэр, нууц үг шаарддаг) байна.



5. Геомэдээллийн систем /Геомэдээллийг цахимаар бүртгэх систем/


Геомэдээллийг бүртгэх, ангилах, харьцуулах, баяжуулах - геомэдээллийг удирдан зохион байгуулах систем бөгөөд Үнэмлэхүй нас, Интрузив чулуулаг, Эффузив чулуулаг, Палеонтологийн олдвор, Горизонт, Стратиграфи /давхарга зүйн сан, Уст цэг /худаг/, Булаг, Илрэл, МонGeoСat/метадата/,



Цахим бүтээлийн сан үүсгэх, Шлихийн хүрээ, Цооног, Өрөмдсөн цооног, Эрдэсэжсэн цэг, Чулуун дээж, Шлиф, Аншлиф, Идэвхтэй хагарал, Гүний хагарал гэх мэт мэдээллийг багтаасан нийт 96942 өгөгдөлтэй гэж тайлагнасан ч уг систем нь зорилтод хэрэглэгчдэд зориулсан (нэвтрэх нэр, нууц үг шаарддаг) байна.

6. Монгеоехр /Хээрийн хөтөч аппликейшн/

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарсан веб газарзүйн системд суурилсан, онлайн болон офлайн горимд ажилладаг, олон нийтэд нээлттэй гар утасны аппликейшн бөгөөд оюутан сурагчид болон аялал жуулчид гэх мэт бүх түвшний хүмүүст зориулагдсан таних мэдэхүйн зориулалттай байна.



2.20. Дээр дурдсан ажлын хэсэг нь одоог хүртэл тус журамд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй ба геомэдээллийн санг эрхлэх үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийг шинэчлэн, найруулснаар 2021 оны 12 сарын 17-ны өдрөөс “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийг дагаж мөрдөхөөр болсон байна.

МЭРГЭЖЛИЙН ГЕОЛОГИЧДООС АВСАН САНАЛ, АСУУЛГЫН ДҮН:

Аудитын явцад Геологийн салбарт Геологийн зураглал, ерөнхий эрэл, ГСА, тэдгээртэй адилтгах бусад судалгааны ажлыг гүйцэтгэж байсан зөвлөх, мэргэшсэн геологич нийт 20 хүнээс 8 чиглэлээр санал асуулгыг авч дүн шинжилгээ хийхэд судалгааны 8 асуулт тус бүрд “Хангалттай” гэсэн хариултыг 2-9 хүн буюу 10-45 хувь нь, “Хангалттай бус”, “Хангалтгүй” гэсэн хариултыг 11-18 хүн буюу 55-90 хувь нь хариулсан байна. Үүнд:

Аудитын судалгаанд хамрагдсан нийт судалгаанд хамрагдсан 20 хүнээс 2 хүн буюу 10 хувь нь 10-15 жил, 3 хүн буюу 15 хувь нь 15-20 жил, 2 хүн буюу 10 хувь нь 20-25 жил, 13 хүн буюу 65 хувь нь 25-аас дээш жил ажилласан хүн байна.

Хүснэгт 21. Санал асуулга, хариултын нэгтгэл

№	Асуулгын агуулга	Судалгаанд хамрагдсан хүний тоо	Хангалттай хариулт өгсөн		Хангалтгүй хариулт өгсөн	
			Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо	Эзлэх хувь
1	“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын төлөвлөлт, даалгавар нь үндэслэлтэй байна уу?	20	8	40 хувь	12	60 хувь
2	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын үр дүн, чанарт бодит хяналт хэрэгжүүлж байна уу?	20	7	35 хувь	13	65 хувь
3	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, түүнтэй адилтгах ГСА нь батлагдсан заавар, тавигдах шаардлага, арга аргачлалд нийцүүлж үр дүн бодитоор гаргаж байна уу?	20	5	25 хувь	15	75 хувь
4	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын төслийн төлөвлөлтөд мэргэжлийн байгууллага, судлаачдаас санал авч, оновчтой хийж байгаа талаарх таны үнэлэмж?	20	5	25 хувь	15	75 хувь
5	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчний нөөцийн талаар таны үнэлэмж?	20	5	25 хувь	15	75 хувь
6	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажилд хэрэглэх норм нь төслийн төсөвт өртөг зохиох, төслийн гүйцэтгэлийг гаргах, төсвийн тодотгол хийх зэрэгт шаардлага хангаж байна уу?	20	2	10 хувь	18	90 хувь
7	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах геологийн судалгааны ажлын санхүүжилтийг бодитой хянаж, холбогдох журмын дагуу хугацаанд гүйцэтгэгч хүлээн авч чадаж байна уу?	20	9	45 хувь	11	55 хувь
8	УТХ-өөр гүйцэтгэж буй 1:50 000 -ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил түүнтэй адилтгах ГСА гүйцэтгэх явцад орон тооны бус зөвлөл болох МСК, РЗ, төрийн захиргааны төв, захиргааны байгууллагын хамтарсан хяналт /суурин болон хээрийн шуурхай/-аар мэргэжил арга зүйн болон зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна уу ?	20	7	35 хувь	13	65 хувь

Эх сурвалж: УАГ-ын санал асуулгын нэгтгэл

ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ЧИГ ҮҮРГИЙГ БУСАД УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН ДҮН:

Монгол Улсын Геологийн салбарын хөгжил, чиг үүрэг, санхүүжилтийн хэлбэр, ил тод нээлттэй байдлыг Олон Улсын түвшинд Австрали, Герман, Канад, БНХАУ болон АНУ зэрэг Холбооны засгийн газар (муж улсуудын холбоо) бүхий улсуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

• Финлянд, Австрали, БНХАУ, АНУ Холбооны засгийн газар (муж улсуудын холбоо), Казакстан Улсын харьяа геологийн албад нь тухайн улсынхаа эрдэс баялаг, байгаль орчны, аж үйлдвэр, инновацын асуудал хариуцсан яамдын харьяа газар, агентлагийн хэлбэрээр геологийн болон далайн ёроолын судалгаа, гүний, гадаргуугийн ус болон хөрс, ашигт малтмал, эрчим хүчний нөөцийг үнэлэх зэргээр системтэй иж бүрэн судалгааг хийж баримтжуулан, иргэдийг нээлттэй мэдээллээр (номын сан) хангах үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа нь явагдаж, улсын төсвийн болон өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжиж хариуцсан яамдад ажлаа тайлагнадаг байна.

Ижил төстэй байдал:

- Улсын төсвийн санхүүжилтээс гадна, геологийн зураг, тайлан, тоон мэдээлэл борлуулах үйл ажиллагаа болон төрийн бусад яам, агентлагуудад үзүүлэх зөвлөх үйлчилгээнээс нэмэлт орлого төвлөрүүлдэг;

- Газар, хөрс, гүний болон гадаргын ус, бохирдол, геологи, ашигт малтмалын чиглэлээр судалгааны мэдээлэл цуглуулж архивлан түгээж байна;

- Хариуцсан сайдад гүйцэтгэлийн үнэлгээний тайлангаа шууд тайлагнадаг.

Ялгаатай байдал:

- Зарим улсын “Геологийн алба” нь геологи, ашигт малтмалын суурь судалгаанаас гадна эрчим хүчний нөөц, байгаль орчны асуудал, тухайн чиглэлийн шинжлэх ухааны судалгааг цогц системтэйгээр гүйцэтгэдэг байна.

Хүснэгт 22. Монгол Улсын болон зарим улс орны Геологийн албадын үйл ажиллагааны чиглэлийн харьцуулалт

Улс	Гадаад улс орны Геологийн албаны үйл ажиллагааны чиглэл
Монгол 	- Төрийн байгууллага; - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа; /хуучнаар/ - Улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг; - Геологи, геоэкологи, гидрогеологи, ашигт малтмал зэргийн суурь судалгаа, мэдээлэл, боловсруулах; - Хайгуулын тайлан, зураглалын тайлан, ТЭЗҮ, бусад тайлан зэрэг архивын баримт, уншлагын танхим; - Тайлан байгаа
Финлянд 	- Төрийн байгууллага; - Хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн яамны харьяа; - Улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг /Засгийн газар төсвийг баталдаг/; - Геологийн судалгаа болон байгаль орчны судалгаа, үнэлгээ - Геологийн болон далайн ёроолын судалгаа гүний, гадаргын ус болон хөрс зэргийн мэдээлэл, номын сан, лабораториор үйлчилдэг. - Тайлан байгаа
Австрали 	- Төрийн байгууллага; - Аж үйлдвэр, инновац, Шинжлэх ухааны яамны харьяа; - Улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг /Засгийн газар төсвийг баталдаг/; - Ашигт малтмал, эрчим хүчний нөөцийг үнэлэх, геологийн суурь судалгаа, мэдээлэл боловсруулах, гүний, гадаргуугийн судалгаа; - Геологийн болон байгаль орчны мэдээлэл, номын сан, - Тайлан байгаа
БНХАУ 	- Төрийн байгууллага; - Газар болон эрдэс баялгийн яамны харьяа; - Улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг /Засгийн газар төсвийг баталдаг/; - Ашигт малтмал, геологи, геофизикийн суурь мэдээлэл боловсруулах; - Геологийн болон ашигт малтмалын мэдээлэл, номын сан, Лаборатори, дээж чулуулгийн төв; - Хийгдээгүй /5 жилийн төлөвлөгөөний биелэлтээр үнэлэгддэг/

АНУ (USGS) 	- Төрийн байгууллага; - Дотоод хэргийн яамны харьяа; - Улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг /Ерөнхийлөгч төсвийг баталдаг/; - Ашигт малтмал, эрчим хүч, геологи хайгуулын судалгаа мэдээлэл боловсруулах, байгаль орчны судалгаа, шинжилгээ - Геологийн болон байгаль орчны мэдээлэл, номын сан, Лаборатори, дээж чулуулгийн төв; - Тайлан байгаа
Казакстан 	- Төрийн өмчит компани; - "Тау-Кен Самрук" ХК нь 100% хувьцаа эзэмшигч; - Өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг; - Геологийн иж бүрэн судалгаа, хатуу ашигт малтмал, гүний усны чиглэлээр

ДҮГНЭЛТ:

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн геологийн судалгааны 1:50000 масштабын зураглал ерөнхий эрлийн ажлын үр дүнгээр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 47.0 хувийг бүрхэнэ гэсэн боловч Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод 0.8 хувиар хангагдаагүй байна.
2. Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлыг төлөвлөхдөө холбогдох журмын заалтуудыг мөрдөөгүйгээс төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байна.
3. Үндэсний геологийн алба, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын үйл ажиллагааны стратегид тусгасан чиг үүргийг холбогдох албан тушаалтны “Ажлын байрны тодорхойлолт”-д бүрэн тусгаагүйгээс үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй, боловсон хүчин, хүний нөөцөөр бүрэн хангагдахгүй байх эрсдэлтэй байна.
4. Үндэсний геологийн албатай Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакцууд нууцлалын гэрээ байгуулаагүйгээс мэдээлэл алдах эрсдэлтэй байна.
5. Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны хөтлөлтөд хяналт хэрэгжүүлээгүй, холбогдох хуулийг зөрчсөн байна.
6. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүн тогтворгүй, зөвлөл нь дүрмийн дагуу үйл ажиллагаагаа бүрэн явуулаагүй байна.
7. Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакц, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл” нь орон тооны бус байгаагаас геологийн судалгааны ажлын үр дүнд үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлээгүй, комисс, зөвлөлийн ажлын уялдаа хангалтгүй, гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй, комисс нь үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, өгсөн санал шүүмж, засвараа эргэж хянадаггүй зэрэг хариуцлагын механизм алдагдсан байна.
8. (тухайн үеийн нэршлээр) БНМАУ-ын Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яамны сайдын 1988 оны 329 дүгээр тушаалаар батлагдсан Геологи үйлдвэр шинжилгээний институтийн эдийн засгийн сектороос боловсруулсан “Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах (ТНЛ) нь өнөөгийн шаардлагыг хангахгүй болсноос гүйцэтгэгч бүрийн геологийн судалгаа, зураглалын ажилд зарцуулагдсан 1км.кв талбайд ногдох төсөвт өртөг, зардал үнийн хэт ялгаатай байдлыг бий болгож байна. (Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв).
9. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын санхүүжилтээс аргачлал, хяналтын зардлыг суутган авсан хэдий ч журмын дагуух арга хэмжээнд зарцуулаагүй байна. (Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв).
10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам нийцээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөлтөд “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 3.1.4 дэх заалтын дагуу үндэслэлтэй, тооцоололтой хяналтыг хэрэгжүүлж, түүнийг баримтжуулж байх.
2. Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаар “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” тогтоолтой холбогдуулан алба хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулахдаа стратегийн чиг үүргийг бүрэн тусгаж байх.
3. Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тавих төлөвлөгөөт хяналтыг тогтмолжуулан эрсдэлийг хянах чадамжийг бий болгож, хяналтын үр нөлөөг сайжруулах.
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлж Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж, мөрдүүлэх.

Үндэсний геологийн албанд:

1. “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын дагуу 3.1 дэх заалтын дагуу геологийн судалгааны ажлыг төлөвлөхдөө эрдэм шинжилгээний байгууллага, мэргэшсэн мэргэжилтнүүдээс санал авах, геологийн судалгааны ажлыг эрэмбэлэх, төсөвт өртгийг үндэслэлтэй тооцоолж, баримтжуулж байх.
2. Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратегийн чиг үүрэгт нийцүүлэн алба хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах.
3. Үндэсний геологийн алба нь Монголын стратиграфийн комисс болон Улсын зургийн Редакцын гишүүдтэй комиссын дүрмийн 2.2, редакцын журмын 2.4 дэх заалтын дагуу тухай бүр нууцлалын гэрээ байгуулах, комисс, зөвлөлөөс судалгааны ажлын үр дүнг үр нөлөөтэй хянах нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагын механизмыг сайжруулах.
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлж Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар зөвлөл”-ийн даргад:

1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгаан асуудал хэлэлцэх салбар зөвлөл” нь үйл ажиллагаагаа ЭБМЗ-ийн дүрмийн 1.4, 5.5, 7.6, 11.4.2 дахь заалтын дагуу явуулж байх.
2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгаан асуудал хэлэлцэх салбар зөвлөл” нь 1988 оны “Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах” (ТНЛ)-ыг хэлэлцэж, дүгнэлт гаргах.
3. Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакц, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “Геологийн судалгаан асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн ажлын уялдааг бүрэн хангаж, геологийн судалгааны ажлын үр дүн, чанарт тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, хариуцлагыг тухай бүр нь тооцож байх

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



**МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-51) 26 35 06,

Цахим шуудан: info@mimr.gov.mn,

Цахим хуудас: www.mimr.gov.mn

2024.12.06 № 03/1214
танай 2024.11.28 -ны № 01/2271 -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Я.САМБУУНЯМ ТАНАА**

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл болон аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад тусгах санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 21 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР



1508 11 0506



**МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,

Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2024.11.09 № 03 | 1150
танай _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Я.САМБУУНЯМ ТАНАА**

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжийг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих ажилд анхаарч, холбогдох эрх зүйн баримт бичигт тусган хэрэгжүүлж ажиллах болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРТЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР



1508 11 0632



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37, 29 дүгээр хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18072
Утас: 7018 1208, 7018 1447, 7018 1206,
Цахим шуудан: info@ngs.gov.mn,
Цахим хуудас: www.ngs.gov.mn

2024.12.06 № 1/432
танай 2024.11.28-ны № 08/2270-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2023 он 08 дугаар тогтоолын дагуу “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”-г үнэлэхээр тус байгууллагад хийгдсэн гүйцэтгэлийн аудитын ГНАГ-2023/29-НА-НА кодтой аудитын тайлангийн төслийг Үндэсний аудитын газраас 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/2270 тоот албан бичгээр ирүүлсэнтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар
1-г үзэх

1. Аудитын тайлангийн “Ерөнхий мэдээлэл” хэсэгт 2018-2024 онуудад Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт түүний үр дүнг дүгнэн бичихдээ ажлын төрөл зүйл, судалгааны зорилго болон хамрах хүрээ /талбай/-г орхигдуулсан хэт ерөнхийлөн тусгасан, түүнчлэн зөвхөн хамрагдсан буюу бүрхсэн талбайг тодорхойлсон дүгнэлт болсон байх тул албаны зүгээс нэмэлт тайлбар танилцуулгыг тайланд нэмж оруулах,

Тайлбар
2-г үзэх

2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, хүлээн авах, баталгаажуулах болон гэрээ дүгнэсний дараа хүрсэн үр дүнгийн талаарх статистик мэдээг гаргах үйл явц нь журам, аргачлалын дагуу тодорхой хугацаа, мөн зохих төрийн байгууллагуудын шийдвэр процесс шаардлагатай байдаг тул тайлангийн “Дүгнэлт” хэсгийн 1 дэх заалтад дурдагдсан тоон үзүүлэлтийг 2024 оны 12 дугаар сарын 2-р хагаст төлөвлөгдөн хуралдааны дэгт орсон төслүүдийн хувь хэмжээг хүлээгдэж байгаа тодотголтойгоор 47.9 хувиар гэж нэмэгдүүлж тайланд оруулах,

Тайлбар
3-г үзэх

3. ҮГА-ны албан хаагчдын АТТ-уудыг ТА3-ийн холбогдох хурлаар хэлэлцүүлж 2021 оны 53, 54, 431 дүгээр тогтоолуудаар батлах зөвшөөрөл авч албаны даргын тушаалаар баталж, мөрдөн ажиллаж байна. Үндэсний геологийн албанаас Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг 2022 онд дахин шинэчлэн батлуулахаар хүргүүлсэн боловч Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дэх хэсэг болон Төрийн албан зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 6.4 дэх хэсэг зэрэг эрх зүйн зохицуулалтуудын хүрээнд шинэчлэн батлуулах боломжгүй хариуг ТА3-өөс ирүүлсэн байдаг тул “Дүгнэлт” хэсгийн 3 дах заалтын холбогдох хэсгийг хасуулан харин “Зөвлөмж” хэсэгт үлдээх,

Тайлбар
4-г үзэх

4. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.9 дэх хэсэгт заасанчлан Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн ЭБМЗ-ийн дүрмийг батлан хэрэгжүүлдэг бөгөөд 2018-2024 онуудад хүчин төгөлдөр байсан дүрмүүдэд ижил агуулгаар орсон “...зөвлөлийн салбар хуралдааны бүрэлдэхүүнийг хуралд оролцсон байдал, ирцийг харгалзан 30 хүртэлх хувийг жил бүр шинэчлэн тогтоож болно” гэсний дагуу бүрэлдэхүүнд

182404 01140

өөрчлөлт орох асуудал нь тус албанаас үл хамаарах тул “Дүгнэлт” хэсгийн 6 дах заалтыг хасуулах,

Тайлбар
5-г үзэх

5. УУХУСайдын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/254, 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/88 дугаар тушаалын хавсралтуудаар УГА-ны зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвчид МСК, Редакцын зөвлөл орон тооны бус бүрэлдэхүүнтэй байхаар баталсан бөгөөд МСК болон Редакцын гишүүдийг сонгон шалгаруулалтын зарчмаар авах ямар нэг эрхзүйн зохицуулалт байхгүй тул “Дүгнэлт” хэсгийн 7 дах заалтын холбогдох хэсгүүдийг хасуулах,

Тайлбар
6-г үзэх

6. Геологи үйлдвэр шинжилгээний институтийн эдийн засгийн сектороос 1988 онд боловсруулан БНМАУ-ын Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яамны сайдын 1988 оны 329 дүгээр тушаалаар батлагдсан Геологи хайгуулын ажлын төсөв зохиох заавар /1988 он/ болон холбогдох “Геологийн хайгуулын ажлын төсвийн нормын лавлах” /ТНЛ/ нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр байгаа бөгөөд геологийн судалгааны ажилд хэрэглэх норм холбогдох аргачлал заавар журмын төслийг Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн сангийн санхүүжилтээр Үндэсний геологийн албатай байгуулсан санамж бичгийн хүрээнд ШУТИС-ийн баг боловсруулж байгаа бөгөөд уг төслийн хэрэгжилт бүрэн хангагдаж 2025 онд эцэслэн дуусах тул “Дүгнэлт” хэсгийн 8 дах заалтыг хасуулан зөвлөмжид үлдээх,


Тайлбар
7-г үзэх

8. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын санхүүжилтээс суутган авсан аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлсэн зарим зардал нь геологи судалгааны ажлын хээрийн болон суурин ажлын явцыг хянах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх, геологичдын мэргэжлийн ур чадварыг сорих, дээшлүүлэх, туршлага солилцуулах, орчин үеийн шилдэг тэргүүний техник технологийг сурталчлах, нэвтрүүлэх, болон хамтрагч орон, хамтрагч байгууллагуудаас геологийн шинжлэх ухааны шинэ ололт, туршлагаас суралцах, санал бодлоо солилцох, төсөл хөтөлбөрт хамрагдах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа авах, жил бүр зохион байгуулдаг геологийн чиглэлийн сургалтуудад геологичдыг хамруулж, чадавхжуулах, дэлхийн геологийн шинжлэх ухааны хөгжилтэй хөл нийлүүлэн алхах, геологийн шинэ мэдээ мэдээллийг үнэ төлбөргүй авах зэрэг зайлшгүй шаардлагаас үүдэн холбогдох тушаал, шийдвэрийн дагуу зарцуулагдсан тул “Дүгнэлт” хэсгийн 9 дэх заалтыг хасуулах зэрэг саналтай байгааг хүлээн авна уу.

Түүнчлэн тайлангийн Хавсралт 3, “Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт”-ын 5 дэх баганад нэмж оруулан хавсралтаар хүргүүлж байгаа шалгагдагч байгууллагын санал, тайлбар хэсэг болон дагалдуулсан нотлох баримттай танилцан эцэслэн шийдвэрлэхдээ харгалзан үзнэ үү.

Хавсралт  хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. МӨНХТӨР

Үндэсний аудитын газрын тайлбар

АҮЭБЯ-ны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 03/1224 дугаартай албан бичгээр алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад 14 тайлбар, санал, УГА-ны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/732 дугаартай албан бичгээр алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад 7 тайлбар, тайлангийн төсөлд 7 санал ирүүлснийг хянаж, тайлангийн 1.21, 1.23, 1.33, 1.34, 1.38, 1.42, 1.43 дахь заалт болон холбогдох дүгнэлтэд найруулгын өөрчлөлт хийж, нийт 9 саналыг хүлээн авч, 19 санал, тайлбарыг хүлээн авах боломжгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Монгол Улсын 2018 он, 2019 он, 2020 он, 2021 он, 2022 он, 2023 он, 2024 оны Төсвийн тухай хуулиар, УУХҮС-ын 2018 оны А/03, А/158 дугаар, 2019 оны А/13, А/109, А/234, А/254 дүгээр, 2020 оны А/232, А/319, А/322 дугаар, 2021 оны А/159, А/294, А/295 дугаар, 2022 оны А/29 дүгээр, 2023 оны А/21, А/379 дугаар “Улсын хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө” тушаалаар батлагдсан геологийн судалгааны ажлын үр дүнгийн нэгдсэн мэдээлэл тул Ерөнхий мэдээлэлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 2	Эрдэс баялгийн мэргэжлийн “ГСАХСЗ”-ийн хуралдаанаар 2020 он, 2021 он, 2022 он, 2023 он, 2024 оны эхний хагас жилд геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн дүгнэлтэд үндэслэсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 3	“Дүгнэлт” хэсгийн 3 дахь заалтыг “Үндэсийн геологийн алба, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын үйл ажиллагааны стратегид тусгасан чиг үүргийг холбогдох албан тушаалтны “Ажлын байрны тодорхойлолт”-д бүрэн тусгаагүйгээс үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байх, боловсон хүчин, хүний нөөцөөр бүрэн хангагдахгүй байх эрсдэл бий болсон байна.” гэж найруулгын өөрчлөлт орууллаа.
Тайлбар 4	Дүгнэлтэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 5	Дүгнэлт хэсгийн 7 дахь заалтыг “Монголын стратиграфийн комисс, Улсын зургийн Редакц, Эрдэс баялгийн мэргэжлийн ГСАХСЗ нь орон тооны бус байгаа нь геологийн судалгааны ажлын үр дүнд үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлээгүй, комисс, зөвлөлийн ажлын уялдаа хангалтгүйгээс гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй, комисс нь үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, өгсөн санал шүүмж, засвараа эргэж хянадаггүй зэрэг хариуцлагын механизм алдагдсан байна” гэж найруулгын өөрчлөлт орууллаа.
Тайлбар 6	Дүгнэлтэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Тайлбар 7	Уул уурхайн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан журмын 3.14, 3.15 дахь, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан журмын 3.2.18, 3.2.19, 3.2.22 дахь заалттай нийцүүлж аргачлал, хяналтын зарим зардлыг төлөвлөөгүй, зарцуулаагүй байх тул дүгнэлтэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

АМГТГ болон ҮГА-аас 2018-2024 онд УУХҮЯ-нд хүргүүлсэн УТХ-өөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын төслийн санал

№	УТХ-өөр хийх ажлын ерөнхий нэршил	Шинээр хэрэгжүүлэх төслийн		
		Хугацаа	Тоо	Нийт төсөв
2018				
1	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	-	7	-
2019				
1	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	-	11	
2	Сэдэвчилсэн судалгаа	-	5	-
2020				
1	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	-	15	-
2	Сэдэвчилсэн судалгаа	-	4	-
2021				
1	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	2021-2024	4	-
2	Сэдэвчилсэн судалгааны ажил	2021-2024	10	-
3	Гадаад хамтын ажиллагааны ажил	2021-2023	1	-
2022				
1	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	2022-2026	8	12,523,820,000.0
2	Региональ судалгаа	2022-2025	3	5,100,000,000.0
3	Сэдэвчилсэн судалгаа: Эрдэс баялгийн судалгаа	2022-2025	3	17,700,000,000.0
4	Сэдэвчилсэн судалгаа: Геомэдээлэл	2022-2025	2	2,250,000,000.0
5	Сэдэвчилсэн судалгаа: Бусад	2022-2025	6	1,220,725,600.0
2023				
1	Геохими-5-200	2023-2026	1	17,548,700,000.0
2	Өмнөговь 2023 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгаа	2023-2025	1	9,800,000,000.0
2024				
1	1:25000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	2024-2027	1	2,250,000,000.0
2	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	2024-2027	10	24,999,300,000.0
3	Сэдэвчилсэн судалгаа: Региональ геологийн судалгаа	2024-2027	4	23,600,000,000.0
4	Сэдэвчилсэн судалгаа: Эрдэс баялгийн судалгаа	2024-2027	5	30,500,000,000.0
Нийт		2018-2027	101	147,492,545,600.0

Хавсралт 2

АМГТГ, УГА-аас УУХҮЯ-нд хүргүүлсэн санал, УУХҮЯ-аас СЯ-нд хүргүүлсэн санал болон УУХҮС-ын тушаалаар баталсан ГСА-ын өөрчлөлтийн хураангуй мэдээлэл

№	Он	АМГТГ болон УГА-аас УУХҮЯ-нд хүргүүлсэн саналын		Хасагдсан		Нэмэгдсэн		УУХҮЯ-аас СЯ-нд хүргүүлсэн саналын		Хасагдсан		Нэмэгдсэн		УУХҮС-ын баталсан тушаалын	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2018	7	-	2	-	3	4,250.0	8	8,450.0	2	3,750.0	1	-	7	-
2	2019	16	-	11	-	25	46,847.8	30	59,527.1	24	45,847.8	11	17,153.3	17	30,658.8
3	2020	19	-	6	-	7	23,000.0	20	39,300.0	5	11,000.0	6	-	21	37,566.2
4	2021	15	-	9	-	4	6,000.0	10	20,140.0	4	8,361.7	9	18,300.0	15	29,178.3
5	2022	22	38,794.5	8	4,320.7	3	10,900.0	17	41,173.8	8	21,623.3	9	17,384.0	18	39,073.8
6	2023	2	27,348.7	2	27,348.7	20	59,400.0	20	59,400.0	20	59,400.0	2	4,198.0	2	4,198.0
7	2024	20	81,349.3	20	81,349.3	1	120,000.0	1	120,000.0	-	89,731.6	-		1	30,268.4
Нийт		101	147,492.5	58	113,018.7	63	270,397.8	106	347,990.9	63	239,714.4	38	57,035.3	81	170,943.5

Эх сурвалж: АМГТГ-ын даргын 2017 оны 1/8749, 2019 оны 3/107, 1/338, 2020 оны 1/449, УГА-ны даргын 2021 оны 1/87, 1/138, 2023 оны 1/26, УГА-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 1/163 дугаар албан бичиг, УУХҮС-ын 2017 оны 01/1301, 2018 оны 01/1479, 2019 оны 01/2326, 2020 оны 01/1392, 2021 оны 01/1380, 2022 оны 01/1605, 2023 оны 01/1444 дугаар албан бичиг, УУХҮС-ын 2018 оны А/03, 2019 оны А/13, А/254, 2020 оны А-322, 2021 оны А/295, 2023 оны А/21, 2023 оны А/379 дүгээр тушаал

Улсын төсвийн хөрөнгөөр 2018-2023 оны хооронд хэрэгжүүлж дууссан судалгааны ажлыг
ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн 2024 оны эхний хагас жилийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын
дэгт тусгасан 21 ажлын жагсаалт

№	Он	Төслийн нэр	Код	Төсөл хэрэгжүүлэгч	ЭБМЗ-ийн ГСАХСЗ-ийн хуралдааны дэгт тусгасан	Үр дүнгийн тайлан дуусах хугацаанаас хойш хэлэлцсэн хугацаа
1	2021-2023	Ховд хотын геозкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил	Ховд- геозкологи- 2021	Эрдэнэс үндэсний судалгаа	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хуралдааны дэгийн 4-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	1 жил
2	2021-2023	Монгол Улсын төв болон хойд хэсэгт хэрэгжүүлэх региональ геологи, сейсмологи, гидрогеологи, хүрээлэн буй орчны геологийн судалгаа	Гүний хагарал-1	Минторис ХХК	2024.06.06-ны өдрийн хуралдааны дэгийн 3-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
3	2018-2022	Дөч гол-50	ДөГ-50	Их цог өндөр ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-05 дүгээр хуралдааны дэгийн 3-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	2 жил
4	2021-2023	Эрэл үнэлгээний судалгааны ажил	ЭҮ-3	Геосигналс ХХК	2024.06.06-ны өдрийн УТХ-2024-08 дугаар хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
5	2021-2023	Эрэл үнэлгээний судалгааны ажил	ЭҮ-2	Меланж сурвэй ХХК	2024.06.06-ны өдрийн УТХ-2024-08 дугаар хуралдааны дэгийн 1-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
6	2021-2023	ӨТТЭ төсөл	ӨТТЭ-1	ГСтөв ТӨҮГ	2024.06.07-ны өдрийн УТХ-2024-09 дүгээр хуралдааны дэгийн 4-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
7	2019-2022	Халзан овоо-50	ХаО-50	Гео-Орон ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-05 дүгээр хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	2 жил
8	2020-2023	масштабын агаарын геофизикийн 5 сүвгийн	Ховд-2020	Геосан ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
9	2019-2022	1:1000000-ын масштабтай Геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх төсөл	Геохими- 2019	Дипирамид ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-05 дүгээр хуралдааны дэгийн 5-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	2 жил
10	2019-2021	ГАСАМ	ГАСАМ	Мянганы хас ХХК	2024.06.06-ны өдрийн УТХ-2024-08 дугаар хуралдааны дэгийн 4-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	3 жил
11	2021-2023	Хойт, төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” хамтарсан төслийн V үе шатны ажил	Төв ази 3D 5-р үе шат	ГСтөв ТӨҮГ	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 6-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	1 жил
12	2019-2022	Оорцог уул-50	ОоУ-50	Монголит ХХК	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 4-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	2 жил

					2024.06.05-ны өдрийн УТХ-2024-07 дугаар хуралдааны дэгийн 4-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	
13	2019-2022	Алаг баян-50	Алб-50	Мадерланд ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хуралдааны дэгийн 3-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх", 2024.06.05-ны өдрийн УТХ-2024-07 дугаар хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	2 жил
14	2019-2022	Өндөр ширээт-50	ӨнШ-50	Их цог өндөр ХХК	2024.03.26-ны өдрийн УТХ-2024-05 дүгээр хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	2 жил
15	2019-2022	Хайрхан овоо-50	ХайО-50	Татах хүч ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-05 дүгээр хуралдааны дэгийн 1-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	2 жил
16	2020-2023	Уушгийн улаан-50	УУ-50	Гео-Орон ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хуралдааны дэгийн 6-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	1 жил
17	2020-2023	Овоот толгой-50	Овт-50	ГСТ ТӨҮГ	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 1-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх", 2024.06.05-ны өдрийн УТХ-2024-07 дугаар хуралдааны дэгийн 1-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
18	2020-2023	Торлог уул-50	ТоУ-50	ГСТ ТӨҮГ	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 2-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	1 жил
19	2020-2023	Цэцэрлэг-50	Цэц-50	Судалт мана ХХК	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 3-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх",	1 жил
20	2020-2023	Их хараат уул-50	ИХУ-50	Геомин ХХК	2024.03.27-ны өдрийн УТХ-2024-06 дүгээр хуралдааны дэгийн 5-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх", 2024.06.05-ны өдрийн УТХ-2024-07 дугаар хуралдааны дэгийн 5-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил
21	2020-2023	Үнэгт уул-50	ҮнУ-50	Монгол алт ХХК	2024.03.25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хуралдааны дэгийн 1-т "Үр дүнгийн тайлан хэлэлцэх"	1 жил

Эх сурвалж: ЭБМЗ-ийн 2024 оны эхний хагас жилийн хуралдааны дэг